

2011 оны Хуваалцах цагийн хөтөлбөр

# Би Судруудын Үнэнийг Мэднэ

*“Дотоод сэтгэл минь судруудад баясна, мөн зүрх минь тэдгээрийг тунгаана”*

*(2 Нифай 4:15).*





Зургийг [sharingtime.lds.org](http://sharingtime.lds.org) -с авч болно.

# Хуваалцах цаг болон Ариун Ёслолын цуглаан дээр хүүхдүүдийн хийх танилцуулгын зааварчилгаа

## Хүндэт Хүүхдийн Хэсгийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийнхөн болон Хөгжмийн удирдагч нар аа,

Судрууд бол Бурханы үг мөн. Залбиралтайгаар судруудаас уншиж, судар дээрх болон энэ хөтөлбөрт заасан зарчмуудыг хэрэгжүүлэх аваас Хүүхдийн Хэсгийн хүүхдүүдэд Есүс Христийн сайн мэдээг заахад та нар сүнслэгээр бэлтгэгдэх болно. Мөн энэ жил та нарын заах ёстой Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө, Есүс Христийн номлол, бошиглогчдын үүрэг, Сүмийн сэргээлт болон ариун сүмийн адислалууд зэрэг сайн мэдээний зарчмуудыг хүүхдүүд илүү сайн ойлгоход туслах судруудыг та нар ашиглах боломжтой болно. Судрууд нь Хүүхдийн Хэсэгт Сүнснийг урьж, хүүхдүүд Ариун сүнсний нөлөөг мэдрэх орчинг бүрдүүлэхэд тань туслах болно. Энэ нөлөө нь Хүүхдийн Хэсэг дэх хүүхэд бүр “Би судрууд үнэн гэдгийг мэднэ” хэмээн хэлэхэд туслах болно.

Та бүхний итгэлтэй шаргуу үйлчлэлд талархъя. Та нарыг итгэлтэй байж чадах чинээгээрээ хүүхдүүдийг хайрлан, тэдэнд Есүс Христийн сайн мэдээг заах болтугай хэмээн бид залбирч байна.

Хүүхдийн Хэсгийн Ерөнхий Ерөнхийлөгчийн Зөвлөл

### Хуваалцах цагт зориулсан зааварчилгаа

#### Сайн мэдээний зааварчилгаа

Долоо хоног тутам хуваалцах цагийн 15 минутын хичээлийг бэлтгэхдээ энэхүү товхимлыг ашиглана уу. Сүмээс зөвшөөрөгдсөн *Найз* эсвэл *Лиакхона сэтгүүлээс материал нэмж ашиглаж болно*. Дараах удирдамжууд хичээлээ төлөвлөж заахад тань тусална.

*Зааж буй хүүхдүүдэд хайрла*. Хүүхдүүдийн сонирхол, авьяас билэг, хэрэгцээ шаардлагыг мөн тэдний нэрсийг мэддэг болсноор тэднийг хайрлаж буйгаа харуул.

*Сургаалыг Сүнсээр заа*. Хичээлээ бэлтгэх явцдаа заах зарчмуудынхаа талаар гэрчлэлээ бэхжүүлж, удирдамж хүлээн авахын төлөө залбир. Энэ нь таныг Сүнсээр заахад туслах болно.

*Суралцах хүсэлтэй болго*. Энэхүү товхимол нь танд зөвхөн юу заахыг хэлээд зогсохгүй хэрхэн зааж, хүүхдүүдийг хичээнгүй суралцдаг болгоход тусалж чадна. Дараах гурван зүйлсийг хичээл бүр дээрээ хэрэгжүүлснээр та сургаалыг илүү үр дүнтэйгээр заах болно.

1. **Сургаалыг ялгаж тань**. Хүүхдүүдийн сурах сургаалыг нь ойлгомжтойгоор танилцуул. Үүнийг хэл яриагаараа болон үзүүлэн ашиглах арга замаар ойлгуул. (Жишээ болгож гурав болон долдугаар сарын эхний долоо хоногийн хичээлийг үзнэ үү.)

2. **Ойлгуулахыг хичээ**. Дуулах, жүжигчилсэн тоглолт үзүүлэх, судруудаас унших зэрэг олон янзын арга хэлбэрээр заах нь тэдэнд сургаалыг гүн гүнзгий ойлгоход нь тусалдаг тул үүнийг чухалчилж авч үз.

3. **Хэрэгжилтийг чухалчлан үз**. Хүүхдүүдэд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэх боломжийг олго. Тэд тухайн сургаалын талаар мэдрэмжээ хэрхэн хуваалцаж болох мөн хэрхэн зорилго тавих арга замуудыг судал.

Энэ товхимолд энэ жилийн зарим долоо хоногт заагдах хичээлийг бүрэн эхээр нь багтаасан. Бусад долоо хоногуудад бүрэн хичээлүүдийг бус харин зөвхөн санаануудыг оруулж өгсөн байгаа. Эдгээр санаанууд дээр өөрийнхөө санааг нэмж баяжуулан ашиглаарай. Та энэхүү товхимолд багтсан зарим хичээлүүдийг уншиж судлан санаа авах боломжтой. Тав дахь Ням гарагт өмнөх үзсэн хичээлүүдээ давтаж сэргээн зааж болно. Хичээлээ төлөвлөж бэлтгэх үед чинь Сүнс таныг удирдан хөтөлнө.

Хичээлээ хөгжмийн удирдагчтай хамтран бэлтгэ. Дуу дуулах нь таны зааж буй сургаалыг тодотгож батжуулахад тусална. Сайн мэдээний зарчмын зааварчилгааг заах үедээ та зарим үед өөр ангийн багш, хүүхдүүдийг хичээлд оролцохыг урьж болно.

**Судрууд:** Хүүхдүүдийг судруудаас суралцахад урьснаар насан туршдаа Бурханы үгийг хайрлах хайрыг хөгжүүлэхэд нь тэдэнд туслах болно. Долоо хоног тутам судраа ашиглаж сурах боломж олгох арга замуудыг төлөвлө. Зарим хүүхдүүдэд судар байхгүй байж мэднэ. Зарим нь уншиж сураагүй байж мэднэ. Энэ товхимлын 8, 13, 24 -р хуудаснууд дахь заахад зориулсан зөвлөмжүүд нь танд судруудыг ашиглан хэрхэн заах талаар тусална.

**Үзүүлэнгүүд:** Энэ товхимол дээрх олон үзүүлэнг [sharingtime.lds.org](http://sharingtime.lds.org) дээрээс авч болно. Мөн сайн мэдээний онцгой сэдвүүдээр өгөгдсөн эх суралжуудын жагсаалтыг Найз болон [friend.lds.org](http://friend.lds.org) дээрээс олж болно. Хүүхдүүдэд заахын тулд эдгээр эх сурвалжуудыг хэвлэн гаргаж, ашиглаж болно.

Зарим хичээл нь Хүүхдийн Хэсэгт үг хэлэх зочин урихыг санал болгодог. Гэхдээ хэн нэгнийг хичээлд тань оролцохыг урихынхаа өмнө бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчөөсөө зөвшөөрөл авах хэрэгтэй.

Таныг заах ур чадвараа сайжруулахад туслах хэд хэдэн зөвлөмжүүд хичээлдүүдэд багтсан байгаа. Тухайн хичээлд холбогдолтой зургуудыг мөн багтаасан болно. Хэдийгээр заах ур чадвар чухал боловч таны сүнснэг бэлтгэл, гэрчлэл нь хүүхдүүдийн зүрх сэтгэлд сургаалуудыг бататгаж өгөх Сүнсийг урьдаг билээ.

## Дуу дуулах цаг

Хүүхдийн хэсгийн дуу хөгжим нь хүндэтгэлтэй нам гүм орчинг бүрдүүлдэг ба сайн мэдээг

заахад Ариун Сүнс болон дуу дуулснаар ирдэг баяр баяслыг мэдрэхэд нь хүүхдүүдэд тусалдаг юм. Хуваалцах цагийн 20 минутыг дуу дуулах болон шинэ дуу заахад зориулах хэрэгтэй. Энэ хугацаа нь шинэ дуу заах болон хүүхдүүд дуулснаар сайхан мэдрэмж хүлээн авах хангалттай цаг болох юм.

Энэхүү товхимолд хүүхдүүдийн энэ жил сурах ёстой шинэ дууг багтаасан ( 28-р хуудсыг үз). Түүнчлэн “Дуу хөгжмийг Хүүхдийн Хэсэгт хэрхэн ашиглах вэ” гэсэн сэдэвтэй хэсгийг оруулж өгсөн (26–27-р хуудсууд) мөн дуунуудыг хүүхдүүдэд заах нэмэлт санаануудыг багтаасан (7 -р хуудсыг үз).



**Бэлтгэл:** Хуваалцах цагаар заах бэлтгэлээ хийхдээ удирдамж болоод Сүнсний нөлөөллийг эрэлхийлэн залбир. Та Сүнсний нөлөөн дор бэлтгэн заахад Сүнс таны зааж буй зүйлсийн үнэнийг батлах болно. (TNGC, 13-г үз)

## Ариун Ёслолын цуглаан дээр хийх танилцуулгын хөтөлбөрт зориулсан удирдамж

Ариун ёслолын цуглаан дээр хүүхдүүдийн хийх танилцуулгыг жил бүрийн дөрөвдүгээр улиралд бишоп буюу салбарын ерөнхийлөгчийн удирдлаган дор хийдэг. Тухайн жилийн эхээр бишопын зөвлөл эсвэл салбарын ерөнхийлөгчийн зөвлөлийн Хүүхдийн Хэсгийг хариуцсан зөвлөлтэй уулзаж урьдчилсан төлөвлөгөөний талаар ярилцах хэрэгтэй. Төлөвлөгөөг бүрэн гүйцэд хийсэн үедээ түүний зөвшөөрлийг ав.


Хүүхдүүдийн хөтөлбөрийг сар тутмын хуваалцах цагийн сэдвүүдэд тулгуурлан төлөвлөсөн байх хэрэгтэй. Хойшид болох танилцуулгын хөтөлбөрт ашиглах зорилгоор жилийн туршид хүүхдүүдийн яриа болон хувийн туршлагаудыг тэмдэглэн

авч болно. Хүүхдийн тухайн жилийн хичээлээс сурсан зүйлээ хуваалцах хөтөлбөрийг төлөвлөхдөө хүүхдүүдийн зааж байгаа сайн мэдээний сургаалд цугларасдыг анхаарлаа хандуулах арга замыг бодоорой. Бишопын зөвлөлийн нэг гишүүн богино дүгнэлтийг хэлж, цуглааныг хаана.

Танилцуулгыг бэлтгэх явцадаа дараах удирдамжуудыг дага:

- Танилцуулгын бэлтгэл нь хичээл болон гэр бүлтэйгээ өнгөрүүлэх цагаас нь хэтрүүлж авахгүй байх ёстой.
- Үзүүлэн, баг өмсгөл мөн телевиз эсвэл иймэрхүү төрлийн танилцуулгуудыг ариун ёслолд ашиглах нь зохисгүй.

*Танилцуулга дээр ашиглах дууг гоцолж эсвэл хоршиж, гэр бүлээрээ эсвэл утсан хөгжмөөр дагалдан хөгжимдөж, том эсвэл жижиг группээр дуулуулж болно. Хүүхдүүд дууны үгийг сайн цээжилсэн мөн өөрсдийн зүрх сэтгэлээс дуулахад нь анхаар.*



## Энэхүү товхимолд ашиглагдсан эх үүсвэрүүд

Тус товхимолд дараах товчлолуудыг хэрэглэсэн:  
ХДН Хүүхдийн дууны ном  
TNGC Teaching, No Greater Call

Хичээлдүүд зурагнууд ашиглахыг зөвлөсөн байгаа. Зургуудыг та Сайн Мэдээний Уран Зургийн Ном, Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга, Хүүхдийн Хэсгийн гарын авлагын зургийн цомгууд, Сүмийн сэтгүүлүүд болон интернет дэх images.lds.org хаягаар орж авч болно.

## 2011 оны сургалтын хөтөлбөр

### Ерөнхий хөтөлбөр

Нярайн бүлэг: Behold Your Little Ones; Нарны цацраг: Хүүхдийн Хэсэг 1; ЗС 4–7; Хүүхдийн Хэсэг 3; Баатарчууд 8–11; Хүүхдийн Хэсэг 7

### Үндсэн сургалтын хөтөлбөр

Нарны цацраг: Хүүхдийн Хэсэг 1; ЗС 4–7; Хүүхдийн Хэсэг 3; Баатарчууд 8–11; Хүүхдийн Хэсэг 7

### Эх сурвалжууд:

Заахад тань туслах материалууд тухайлбал будах хуудас, түүх, үйл ажиллагаанууд зэрэг нэмэгдэл эх сурвалжуудыг Найз, Лиэхона, нярайн ангийн гарын авлага, Сайн мэдээний зургийн цуглуулга дээрээс авч болно. Эдгээр эх сурвалжуудыг ашиглан хичээлээ баяжуулан дэлгэрүүл.

# Судрууд бол Бурханы үг мөн

“Христийн үгэн дээр найрла, учир нь болгоогтун, Христийн үгс та нарын хийвэл зохих бүх зүйлийг та нарт хэлэх болно” (2 Нифай 32:3).

Энд дурдах санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд сургаалыг ялган таньж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн Ариун Сүнснийг мэдрэхэд нь би хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.

## Эхний долоо хоног: Судрууд бол Бурханы үг мөн.

### Сургаалыг ялгаж тань (номнуудыг харж):

Янз бүрийн (хоолны, түүхийн, сургуулийн гэх мэт) номнуудыг Хүүхдийн Хэсэгт авчирч, хэдэн хүүхдүүдийг урьж, тэдгээр номнуудыг болон судруудыг хүүхдүүдэд үзүүлэхийг хүс. Номыг бичсэн зохиогчийг оролцуулан тэдгээрийн хоорондох ялгаа болон ижил зүйлсийг олж, хэлэлцэхийг хүүхдүүдээс хүс. Судрууд нь Бурханы бошиглогчдоор бичиглэгдсэн Бурханы үгс тул онцгой гэдгийг тодотгон хэл.

### Ойлгуулахыг хичээ (тохируулан нийлүүлэх тоглоом тоглож):

Сүм дээр ашигладаг: Ариун Библи, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Ариун Үнэт Сувд гэсэн дөрвөн ном байдгийг

хүүхдүүдэд хэл. Бид эдгээр номнуудыг “жишиг бүтээлүүд” гэж нэрлэдгийг тайлбарла. Ном бүрийн талаар хүүхдүүдэд заа. Ном бүр дээрх цөөн хэдэн түүхүүдээс эсвэл сургаалаас заа. Жишиг бүтээлүүдийн нэр, түүхүүдийг харуулсан зурагнууд эсвэл ном бүрээс олдох сургаалтай холбоотой тохируулан нийлүүлэх тоглоом тогло (TNGC, 169-г үз).

### Хэрэгжилтийг урамшуулан дэмж (судруудаас хуваалц):

Хэдэн хүүхдийг өөрсдийн дуртай судар болон судрын түүхээс хуваалцахыг хүс. Тэднийг судруудаас олж мэдэж авсан зүйлсээ хуваалцахыг урамшуулан дэмж. Судруудын талаарх өөрийн гэрчлэлээ хуваалц.

## Хоёр дахь долоо хоног: Бид Христийн үгэн дээр найрлах ёстой.

### Ойлголт ба хэрэгжилтийг чухалчил (үгс ба хэллэгт суралцсанаар):

Бид судруудаас хэрхэн судлах ёстойг ойлгуулахын тулд Их Эзэн үйлдэлт үгсийг ашигладаг гэдгийг тайлбарла. Өрөөнд дараах үгс ба хэллэгийг тойруулан тавь: найрла (2 Нифай 32:3-ийг үз); ямагт нөөцөл (С ба Г 84:85-ийг үз); хичээнгүйлэн судлах (Мозая 1:7-ийг үз); зууран барих (1 Нифай 15:24 –г үз). Эдгээр санаануудыг хүүхдүүдэд тайлбарлан, ойлгуулах бүтээлч арга замуудыг төлөвлө. Жишээ нь, хоол хүнсэн дээр үмх юм идэх ба найрлах гэдгийн хоорондох ялгааг үзүүлэхийг хүүхдүүдээс хүсч, дараа нь судруудаас судлах явцтай энэ нь хэрхэн холбогдож байгааг ярилцаж болно. Олон түмэн бужигнасан дэлгүүр хоршоо зэрэг газруудад яагаад тэд эцэг эхийнхээ гараас “зууран барих” ёстойг асуу. Дараа нь тэд хэрхэн судруудаас

зууран барих ёстой бөгөөд энэ нь эцэг эхийнхээ гараас зууран барихтай адил чухал гэдгийг тайлбарла.

### Хэрэгжилтийг урамшуулан дэмж (судруудаас уншиж):

Хүүхэд болон багш нарыг судраас байнга судлах зуршилтай болоход уриалан дууд. Судруудаас уншсан эсвэл сонссон хүүхдүүд цаасан дээр нэрээ бичиж, цаасаар хийсэн гинжин хэлхээнд нэмэх боломжтойг долоо хоног тутамд сануулан тайлбарла. Цаасан хэлхээ ихсэх тусам тэдний судруудын мэдлэг өсөн нэмэгддэг гэдгийг тэдэнд хэл. “Эрдэнэсийн нөөц” хайрцганд хэлхээг хадгал (энэ хайрцгийг мөн дээрх үйл ажиллагааны “ямагт нөөцөл” гэдэг үг ямар утгатай болохыг заахад ашиглаж болно). Өөрсдийн судруудаас судлах зорилго тавин гэр бүлтэйгээ судар хуваалцахыг урамшуулан дэмж.



**Жилийн уриа:** Жилийн турш судраас уншиж суралцсан өөрсдийн гэрчлэлийг хуваалцах боломжийг хүүхдүүдэд өг. Энэ нь өөрсдийн туршлагаас хуваалцах боломжийг хүүхдүүдэд өгөх ба бусдыг гэртээ судар уншихад өдөөж туслах болно.



Энэ гинжин хэлхээ нь судар уншсанаар ирэх өсөлт хөгжилтийг сануулах үзүүлбэр болж чадна.

## Гурав дахь долоо хоног: Хийвэл зохих бүх зүйлийг Христийн үгс бидэнд хэлэх болно.

**Ойлгуулахыг хичээ** (*хичээлийн сэдвийг харуулан*): Нэг хүүхдийн нүдийг боо. Өөр хүүхэд Есүс Христийн зургийг ангийнхаа өрөөний хаа нэгтээ барин зогсоно. Нүдээ боосон хүүхдээс хэн нэгний тусламжгүйгээр зургийн байгаа газрыг олохыг хүс. Үйл ажиллагааг давтан хий. Харин энэ удаа Христийн зураг уруу хөтлөх төмөр бариулыг орлох олс, утас эсвэл уяаг хоёр хүүхдэд бариулан нүдээ боосон хүүхдийг тэр уяанаас барьж авахыг хүс. Хүүхдээс зураг уруу хөтлөх бариулыг даган явахыг хүс. “Бариулаас барих нь судрууд уншихтай хэрхэн холбогдож байна вэ?” гэж асуу. (1 Нифай 15:23–25-ыг үз). Хүүхдүүдэд “Төмөр бариул” дууг заа (*Дуулал, дугаар 274*). Судрууд танд юу хийхийг зааж байсан амьдралынхаа бодит жишээнээс хуваалц. Судрууд дээрх сургаалуудыг дагаснаар хэрхэн Аврагчид ойр байхад тань тусалсан тухай тайлбарла.



*Хичээлтэй холбоотой бодит зүйлсийг хичээлд ашиглах нь хүүхдүүд энгийн бөгөөд танил зүйлсээр дамжуулан хэлэх санааг илүүтэй сайн ойлгоход тусалдаг (TNGC, 164-г үз).*

## Дөрөв дэх долоо хоног: Би судрууд үнэн гэдгийг мэдэж чадна.

**Ойлгуулахыг хичээ** (*дуу дуулж*): Хүүхдүүд өөрсдийн таван мэдрэхүйгээ ашиглаж сурахад нь туслах нэг эсвэл хоёр зүйлийг авчир. Жишээ нь, жимс, цэцэг, эсвэл та тэдэнд хөгжим тоглож өгч болно. Авчирсан зүйлсээрээ цөөхөн хүүхдэд харах, үнэртэх, барьж үзэх, амтлах эсвэл сонсох боломжийг өг. (Хүүхэд бүр үйл ажиллагаанд оролцох боломжтой байхын тулд энэ үйл ажиллагааг цөөхөн хүүхэдтэй ангид хийх ёстойг анхаарна уу.) Бид мөн судруудыг харж, барьж, үнэртэж, сонсож чадна гэдгийг үзүүл. Харин тэдгээрийн тухай гэрчлэлтэй болохын тулд бид Сүнсний гэрчлэл хүлээн авах хэрэгтэй. Хүүхдүүдтэй хамт “Эрэлхийлж, эргэцүүлэн бодож, залбир” дууг дуул (*ХДН, 66*). Дууг дуулахдаа Сүнс бидэнд судрууд



үнэн гэдгийг гэрчлэх гурван зүйлийг олж сонсохыг тэднээс хүс. *Эрэлхийл, эргэцүүлэн бод, залбир гэсэн гурван үгийг хэлэхдээ гараа өргөхийг хүүхдүүдээс хүс. Эдгээр үгс хэлэгдэхэд гарын хөдөлгөөнөө хийж, дууг давтан дуул.*

**Хэрэгжилтийг урамшуулан дэмж** (*мэдрэмжээ хуваалцан*): Моронайгийн зургийг үзүүлж, Моронай 10:4–5-г унш. Хэдэн хүүхдийг урьж, судруудын талаарх мэдрэмжээ хуваалцахыг хүс. Тэд гэртээ судар уншихын тулд юу хийсэн тухайгаа хуваалцахыг хүс. (Бэлтгэх хугацаатай байхын тулд хэдэн хүүхдэд урьдчилан хэл.) Хүүхдүүд гэртээ эцэг эхтэйгээ судруудын тухай өөрсдийн гэрчлэлийг хуваалцахыг урамшуулан дэмж.

**Бүх хүүхдийг хамруулах нь:** Жилийн турш судруудаас унших үйлсэд Хүүхдийн Хэсгийн бүх хүүхдүүдийг хамруулах арга замуудыг олж тогтоо. Жишээ нь, гэртээ судар унших боломжгүй хүүхдүүдэд сүм дээр унших боломжоор хангаж, дараа нь тэдний нэрсийг цаасан хэлхээнд нэм.



**Жижиг группууд:** Жижиг групп нь хүүхдүүд үйл ажиллагаанд илүүтэй хамрагдах боломжийг өгдөг (TNGC, 161-г үз). Хүүхдүүд ангидаа групп болон сууцгаасан байна. Эдгээр группуудыг жижиг группээр хийж болох үйл ажиллагаануудад ашиглаж болно. Багш нар хүүхдүүдийн оролцоо хийгээд хүндэтгэлтэй байдлыг хадгалахад нь тусална.

# Судрууд Тэнгэрлэг Эцэгийн ТӨЛӨВЛӨГӨӨГ заадаг

**Дуу: “Би Бурханы төлөвлөгөөг дагана”**  
(ХДН, 86)



## Ойлголтыг бэх-

**жүүлэх нь:** Хүүхдийн Хэсэгт сурсан зүйлсээ бусадтай хуваалцах нь тэдний сургаалын талаарх ойлголт болон гэрчлэлийг бэхжүүлдэг. Үүнийг ангид хийх боломжийг тэдэнд өгөх тухай бод. Тэгээд гэртээ суралцсан зүйлсээсээ хуваалцахыг урамшуулан дэмж.

**Гэрчлэл:** Хичээлийн явцад богино гэрчлэл хуваалцах нь үргэлж Сүнсний урьдаг. Энэ нь “Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө бидэнд аз жаргалыг авчирдаг” гэж энгийнээр хэлэх эсвэл “Би өөрийн гэрчлэлийг хуваалцамаар байна” гэж хэлэх нэлээд албан ёсны гэрчлэл ч байж болно. (TNGC, 43–44-г үз.)

Тэр “Учрыг болгоогтун, үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах нь миний ажил мөн миний алдар суу бөлгөө” гэж хэлсэн (Моисе 1:39).

Энд дурдах санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд сургаалыг ялган таньж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн Ариун Сүнснийг мэдрэхэд нь би хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.

## Эхний долоо хоног: Тэнгэрлэг Эцэгт надад зориулсан төлөвлөгөө бий.

**Сургаалыг ялгаж тань:** Байшингийн зураг хүүхдүүдэд үзүүл. Байшин барихын тулд байшин барих төлөвлөгөө байх хэрэгтэй гэдгийг тайлбарла. “Төлөвлөгөө хийж, түүнийг дагах нь яагаад чухал вэ?” гэж асуу. Судруудыг гартаа өргөн барьж, Тэнгэрлэг Эцэгийн бидэнд зориулсан төлөвлөгөөг судруудаас олж болно гэдгийг хүүхдүүдэд хэл. Самбар дээр “Тэнгэрлэг Эцэгт надад зориулсан төлөвлөгөө бий” гэж бич. Өгүүлбэрийг бүгд хамтдаа унш.

**Ойлгуулахыг хичээ (дуу дуулж):** Самбар дээр дараах асуултуудыг бич:

- Би хэн бэ?
- Би хаанаас ирсэн бэ?

- Яагаад би энд байгаа вэ?
- Үхлийн дараа надад юу тохиолдох вэ?

Хүүхэд бүрт: хэн, хаана, яагаад эсвэл юу гэж бичсэн цаас өг. Самбар дээрх эхний асуултыг хамтдаа унш. Тэгээд хэн гэсэн бичигтэй цаас авсан хүүхдүүдийг босохыг хүс. “Би Бурханы хүүхэд” дууг дуулж (CS, 2–3) Дараа нь боссон хүүхдүүдээс ямар хариулт өгөхийг асуу. Асуулт бүрийг энэ маягаар дараах дуунуудыг ашиглан асуу: хаана: “Би тэнгэрт амьдардаг байсан” (CS, 4); яагаад: “Би Бурханы төлөвлөгөөг дагана” (ХДН, 86); юу: “Есүс үнэхээр дахин амилсан уу?” (ХДН, 105) Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө бидэнд аз жаргалыг авчирна гэдгийг гэрчил.

## Хоёр дахь долоо хоног: Есүс Христ надад зориулж дэлхийг бүтээсэн.

**Ойлгуулахыг хичээ (зураг зурж):** Хүүхдүүдтэй хамт гутлаа үдэх эсвэл унтахаар ороо засах зэрэг үйлдлийг ямар дэс дараалалтай хийдэг талаар бод. Есүс мөн тодорхой дэс дарааллаар дэлхийг бүтээсэн гэдгийг судраас суралцаагчийг тайлбарла. Хүүхдүүдийг зургаан групп болгон хувааж, групп бүрт Бүтээлтийн нэг өдрийг дүрсэлсэн судрын эшлэл өг (Моисе 2-г үз). Групп бүрээс тэр өдрийг дүрсэлсэн зураг зурахыг хүс. Бусад хүүхдүүдэд өөрсдийн зурсан зургийг үзүүлж, тэр өдөр юу бүтээснийг тэдэнд хэл. Самбарт зохих дэс дарааллын дагуу зурагнуудаа байрлуулахыг хүс.

**Хэрэгжилтийг урамшуулан дэмж (баримлын шавраар тоглож эсвэл зураг зур):** Хүүхдүүдээс “Есүс та нарт чухал болох ямар зүйлийг бүтээсэн бэ?” гэж асуу. Хүүхэд бүрт баримлын шавар өг (TNGC, 165, давстай зуурмаг хийх жор). Тэдний хувьд хамгийн чухал зүйлээ баримлын шавраар бүтээхийг хүс. (Хэрэв баримлын шавар байхгүй бол хүүхдүүдээр зураг зуруул.) Хүүхдүүдийн хийсэн зүйл эсвэл зурсан зургийг үзүүлж, яагаад энэ нь түүнд тийм чухал болохыг хуваалцахыг тэднээс хүс. “Тэнгэрлэг Эцэг минь намайг хайрладаг” дууг дуул (ХДН, 16).



## Гурав дахь долоо хоног: Гэр бүлүүд Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний чухал хэсэг.

### Сургаалыг ялгаж тань (цээжилсэнээр):

Дараах өгүүлбэрийг самбарт бич: “Гэр бүлүүд Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний чухал хэсэг” Энэ өгүүлбэр ямар утгатай болохыг ярилц. Өгүүлбэрийг арилга. Эхний хоёр үгийг хэл. Тэгээд хүүхдүүдийг давтан хэлэхийг хүс. Дараа нь эхний дөрвөн үгийг хэл. Хүүхдүүдийг давтан хэлэхийг хүс. Бүтэн өгүүлбэрийн үгсийг хэлж дуустал үргэлжлүүл.

**Ойлгуулахыг хичээ (асуулт хариултын аргаар):** Хэдэн хүүхдээс судар дээрх гэр бүлүүдийг танилцуулахыг хүс. Гэр бүл бүрийн тухай хэдэн тайлах түлхүүр үгсийг бэлтгэ (жишээ нь, Адам Ева хоёр: “Манай гэр бүл дэлхий дээрх хамгийн анхны гэр бүл байсан”; Абрахам ба Сара: “Бид нэлээд нас ахисан хойноо хүүхэдтэй болсон”; Лихай ба Сариа: “Бид амлагдсан газарт очихоор их далайг гаталсан”). Тэдгээр түлхүүр

үгсийг хүүхдүүдэд хэл. Боломжтой бол энгийн жүжгийн хувцас бэлтгэ. Групп бүрээс тухайн судрын гэр бүлийг төлөөлж байгаа хүүхдүүдээс самбарын өмнө ээлжлэн гарч ирэхийг хүс. Өөрсөддөө оногдсон тайлах түлхүүр үгсийг уншиж, Хүүхдийн Хэсгийн бусад хүүхдүүдээс аль гэр бүлийг танилцуулж буйг асуу. Гэр бүл бүрийг таньсны дараа судрууд дээр эдгээр гэр бүлүүдийн талаар хаанаас уншиж болохыг үзүүл. Тэдэнд зориулсан Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг эдгээр гэр бүлүүд хэрхэн дагасан тухай хүүхдүүдэд хэл.

**Хэрэгжилтийг урамшуулан дэмж (гэр бүлүүдийн тухай ярилцаж):** Тэдний гэр бүлийн сайн чанаруудын тухай бодохыг хүүхдүүдээс хүс. Тэдгээр чанаруудын тухай группынхээ бусад хүүхдүүдтэй эсвэл нийт Хүүхдийн Хэсэгтэй хуваалцахыг хүүхдүүдээс хүс.



Хүүхдийн Хэсгийн хүүхдүүдийн насанд нь зохицуулсан **үйл ажиллагаанууд** (TNGC, 110–117-г үз). Жишээлбэл, гурав дахь долоо хоногийн хоёр дахь үйл ажиллагаанд ахмад хүүхдүүдээс судруудын гэр бүлүүдийг танилцуулах тухай тайлах түлхүүр үгсийн оронд, тийм эсвэл үгүй гэсэн хариулт авах асуултууд асууж болно.

## Дөрөв дэх долоо хоног: Би Бурханы төлөвлөгөөг дагана.

**Ойлгуулахыг хичээ (хичээлтэй холбоотой бодит зүйлсийг үзүүлж):** Хэсэг вандуй эсвэл жижиг чулуунууд ба инээмсэглэсэн дүрс наасан хоосон жимсний чанамлын шил үзүүл. Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө бидэнд зөв ба бурууг сонгох эрхийг өгдөг гэдгийг хүүхдүүдэд хэл. Буруу сонголт нь боолчлол ба аз жаргалгүй байдал уруу хөтөлдөг бол зөв сонголт нь эрх чөлөө ба аз жаргалд хөтөлдөг гэдгийг тайлбарла (2 Нифай 2:27-г үз). Хүүхдүүдээс “Бурханы төлөвлөгөөг дагах ямар зарлигуудыг сахидаг вэ?” гэж асуу. Асуултанд хариулсан хүүхэд бүрт нэг вандуй өг. Хариултыг самбарт бич. Вандуй авсан хүүхэд бүрээс зарлигуудыг сахиу нь тэднийг хэрхэн аз жаргал уруу хөтөлдгийг асуу. Дараа нь вандуйгаа шилэнд хийхийг түүнээс хүс. Хэрэв бид Бурханы төлөвлөгөөг дагахыг сонговол, бидний амьдрал аз жаргалаар дүүрэн байх болно гэдгийг гэрчил.

**Хэрэгжилтийг урамшуулан дэмж (туг хийж):** Анги бүрт зориулж туг хэлбэртэй

том цаас бэлтгэ. Туг бүр дээр “Би Бурханы төлөвлөгөөг . . . дагана” гэж бич. Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө нь бидэнд зөв ба бурууг

### Туг далбаа харахад энд дар.



сонгох эрх чөлөөг өгдөг ба бид өдөр бүр ямар сонголт хийх нь бидний аз жаргалд чухал ач холбогдолтой байдгийг тайлбарла. Ангийн хүүхдүүдээс Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг дагаж чадах зүйлсийг туган дээр бичих эсвэл зурж, өөрсдийн нэрийг бичихийг хүс. Өөрсдийн туган дээр юу зурж эсвэл бичсэнээ ангийнхандаа үзүүлэхийг хүс. Хүүхдүүдийг тугаа барьж, “Би зоригтой байна” (ХДН, 85) дууг дуулан, алхахыг хүс. Хүүхдийн Хэсгийн өрөөнд тугнуудыг байрлуулан тавь.



### Инээмсэглэсэн царай харахад энд дар.



Хүүхдүүдийн эрч хүчийг хичээлийн турш идэвхтэй, сонирхолтой байлгахад туслах зохистой хөдөлгөөн хийж байхад анхаар.

Дуу: “Үнэний төлөө зогс” (ХДН, 81)



**Хүндэтгэл:** Хүүхдүүд суралцах явцад идэвхтэй оролцсон тохиолдолд илүү хүндэтгэлтэй байдаг. Нэг ба хоёр дахь долоо хоногийн үйл ажиллагаанууд нь олон хүүхдийг хамруулдаг. Тоглолтонд оролцоогүй хүүхдүүд нас чацуутнууд нь тоглолтонд оролцож байгааг хараад оролцохыг хүсдэг. (TNGC, 82–83-г үз)

# Тэнгэрлэг Эцэг Өөрийн бошиглогчдоор дамжуулан бидэнтэй ярьдаг

“Их Эзэн миний бие ярьснаа би ярилаа, . . . харин миний өөрийн дуу хоолой байна уу, эсвэл миний үйлчлэгчдийн дуу хоолой байна уу, энэ нь яг адил, бүгд биелэгдэх болно” (С ба Г 1:38).

Энд дурдах санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд сургаалыг ялган таньж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн Ариун Сүнснийг мэдрэхэд нь би хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.

## Нэг ба хоёр дахь долоо хоног: Бошиглогчид Тэнгэрлэг Эцэгийн өмнөөс ярьдаг.

**Сургаалыг ялгаж тань** (биеэр үзүүлж): Нэг хүүхдийг самбарын өмнө гарч ирэхийг урь. Бусад хүүхдүүдийг түүний удирдамжийг дагахыг хүс. Хүүхдийн чихэнд “Тэднийг толгой дээрээ гараа тавихыг хүс” эсвэл “Хажуугийнхаа хүүхдэд чимээгүйхэн сайн байна уу гэж хэл” гэх мэт энгийн удирдамжийг шивнэн хэл. Бусад энгийн удирдамжуудыг хэлж хийлгэсний эцэст “Тэднийг гараа хумхин суухыг тэдэнд хэл” гэнэ. Та тэднээс юу хийхийг хүсэнийг тэд хэрхэн мэдсэн бэ гэдгийг хүүхдүүдээс асуу. Тэнгэрлэг Эцэг ба Есүс Христ дэлхий дээрх хүмүүс уруу захиас илгээдэг арга замуудын нэг нь Өөрсдийн үйлчлэгч нартаа ярьж, дараа нь тэдгээр үйлчлэгчдийг хүмүүст хэлэхийг тушаадаг тухай тайлбарла. “Тэнгэрлэг Эцэг ба Есүсийн өмнөөс ярьдаг үйлчлэгчид нь хэн бэ?” гэж асуу. Хүүхдүүдийг хамтдаа “Бошиглогчид Тэнгэрлэг Эцэгийн өмнөөс ярьдаг” гэж хэлүүл.

**Ойлгуулахыг хичээ** (судрын түүхүүдийн дүрд тоглох): Хүүхдийн Хэсэг эхлэхийн өмнө бошиглогчийн зургийг мөн түүний хийсэн эсвэл хэлсэн судрын зарим эшлэлүүдийг зарим сандлын дор хад. Жишээ нь, Ноа (Эхлэл 6:13–14; 7:5, 7–10); Моце (Египетээс Гарсан нь 14:8–9, 13–14, 21–22); Лемен үндэстэн Самуел

(Хиламан 14:1–8; 16:1–3); ба Иосеф Смит (С ба Г 89). Сандал доорх зурагнуудыг олохыг хүүхдүүдээс хүс. Хүүхдүүдийг групп болгон хувааж, групп бүрт нэг зураг өг. Өөрсдийн бошиглогчийн тухай тоглолт бэлтгэхийг тэднээс хүс. Хэн гэдэг бошиглогчийг үзүүлж байгааг бусад хүүхдүүдээр таалга. Хүмүүс бошиглогчийн захиасыг хэрхэн хүлээн авсан болон үр дүнгүүд нь ямар байсан тухай ярилц.

**Ойлгуулахыг хичээ** (дуу дуулж): Энд үзүүлсэнтэй адил “Бошиглогчдын дугуй” хий. Дугуйг найман хэсэг болгон хуваа. Хэсэг бүр дээр “Бошиглогчийг дага” (ХДН, 58) дуунд гарах бошиглогчийн нэрийг бич. Нэг хүүхдээс дугуйг эргүүлэхийг хүс. Дугуйн дээрх бошиглогчийн тухай богинохон түүх хуваалц (санаа авахын тул ХДН, 58, дээрх судрын эшлэлүүдийг ашигла). Дараа нь “Бошиглогчийг дага” дуун дээрх бошиглогчийн тухай мөрийг дуул. Өөр нэг хүүхдээс дугуйг эргүүлэхийг хүс. Цагтаа багтаан үйл ажиллагааг үргэлжлүүлэн хий.



Бошиглогчдын дугуйг харахад энд дар.

## Гурав дахь долоо хоног: Өнөөдөр биднийг амьд бошиглогч удирддаг.

**Ойлгуулахыг хичээ** (бошиглогчийн сургаалуудын талаар яриу): Цаасыг дөрөв хуваан хайчилж одоогийн бошиглогчийн зурган дээр тэднийг байрлуул. Цаас бүрийн ар талд бошиглогчийн сургаалаас бич. (Ensign эсвэл Лиахона дээрх ерөнхий чуулганы материалаас саяхан бошиглогч юу гэж хэлснийг суралц.)

Нэг хүүхдээс нэг цаасыг авч, түүн дээрх сургаалыг үйлдлээр харуулахыг хүс. Харин бусад хүүхдүүд тухайн хүүхдийн юу хийж байгааг таах хэрэгтэй. Бусад хэсгүүдийг авч, сургаалуудыг түрүүчийн адил таалга. Найз эсвэл Лиахона сэтгүүлийг үзүүлж, бид өнөөгийн





бошиглогчийн үгсийг эндээс уншиж болохыг тайлбарла.

**Хэрэгжилтийг урамшуулан дэмж** (санаануудыг хуваали): Нэг хүүхдийг босгоод, энэ тунхаглалыг гүйцэд өгүүлбэр



болгон хэлэхийг хүс: “Би амьд бошиглогчийг . . . дагах болно.” Өөр нэг хүүхдээр бошиглогчийг дагах бас нэг арга замыг эхний хүүхдийн тунхаглал дээр нэмэн хэлэхийг хүс. Хичээлийн цагтаа багтаан, аль болох олон хүүхдийг оролцуулан, бусад хүүхдүүдийн санаануудыг хэлүүлэн давтан хий.



*Хүүхдүүд хувийн бодит хэрэглээгээр дамжуулан сургаалыг илүү сайн хэрэгжүүлдэг. Мөн тэдний санаануудыг багш болон бусад хүүхдүүд давтан хийсэн тохиолдолд илүү их хайр, баталгааг мэдэрдэг.*

**Дөрөв дэх долоо хоног: Бошиглогчийг дагаснаар аюулгүй байж чадна**

**Ойлгуулахыг хичээ** (дуу дуулж, түүхүүдийг сонсож): Замын хөдөлгөөний “Зогс”, “Хурдаа хас”, “Яв” гэсэн энгийн тэмдгүүдийг бэлтгэ. Тэмдгүүдийг барин зогсох гурван хүүхэд сонго. Хөгжмийн удирдагч тэдний мөрөнд хүрэхэд тэд тэмдгээ өргөнө. Яв гэдэг тэмдэг дуулж эхлэх дохио; Зогс гэдэг тэмдэг дуулахаа болих; Хурдаа хас гэсэн тэмдэг удаан дуулна гэсэн утгатай болохыг хүүхдүүдэд хэл. Хөгжмийн удирдагч хүүхдүүдийг удирдан “Үнэний төлөө зогс” (ХДН, 81) дууг дуул.

Замын хөдөлгөөний тэмдгүүд нь биднийг аюулаас хамгаалж, өмнө маань аюул байгааг анхааруулдаг гэдгийг тайлбарла. Дараа нь бошиглогчийн удирдамжуудыг дагавал Тэнгэрлэг Эцэг биднийг хамгаалж, адисалдаг учир эдгээр замын хөдөлгөөний тэмдэгтэй адил

гэдгийг тайлбарла. Хүүхдүүдийг гурван групп болгон хуваа. Групп бүрийн удирдагч эсвэл ахмад хүүхэд бошиглогчийг дагаснаар хэрхэн хамгаалагдсан тухай өөрийн түүхээс (эсвэл сударт гардаг хэн нэгний түүхээс) хуваалц. Дараа нь группуудыг бусад группын удирдагч дээр очин өөр түүх сонсохыг хүс. Групп дамжин түүх сонсон явахдаа хамтаараа “Бошиглогчийг дага” дууг дуулахыг хүс. Бошиглогчийг дагаснаар ирсэн адислалуудын тухай гэрчил.

**Хэрэгжилтийг урамшуулан дэмж** (тэмдгүүд хий): Хүүхдүүдээр хувийн замын хөдөлгөөний тэмдэг хийлгэж, түүн дээр нь амьд бошиглогчийн сургаалуудыг хэрхэн дагах тухай бичүүл. Бошиглогчийг дагах ёстойгоо үргэлж санаж байхын тулд хийсэн тэмдэгнүүдийг нь гэрт нь өгч явуул.



*Хэв загвар харахад энд дар.*



**Хөгжмийн удирдагчид зориулсан тусламж**

Дараах зүйлсийг анхааран үзэж, “Үнэний төлөө зогс” дууг сурахад нь хүүхдүүдэд тусал (ХДН, 81):

- Одоогийн бошиглогчийн зургийг үзүүлж, түүний бидэнд өгсөн зарим удирдамжуудын талаар товчхон ярилц. Тэдний сурч байгаа дуу бошиглогчийг дагах нь ямар чухал ач холбогдолтой байдаг тухай хүүхдүүдэд хэл.
- Хүүхдүүдийг группуудад хуваа. Групп бүрт дууны нэг буюу хоёр мөрийг өг. Үгийг цээжлэхэд нь туслах үйлдэл зохион, хийхийг хүс. Групп бүрээс өөрсдийн үйлдлийг бусад хүүхдүүдэд заахыг хүс.



*Хүүхдүүдэд дуу зааж байхдаа гараар хөгжмийн хэмнэлийг үзүүлэн дохь. Дууны хэмнэл өөрчлөгдөх үед гараа өргөж, буулга (TNGC, 174-г үз).*

**Дуунууд:** Сургаалын тухай дуулах нь түүнээс суралцаж, санаж байхад нь хүүхдүүдэд тусалдаг. Мөн хүүхдүүд үзүүлэн эсвэл хөгжимт үйл ажиллагаа хийхэд илүү сайн суралцдаг. Энэ сард зориулсан үүнийг хийх хэд хэдэн өөр арга замуудтай зөвлөмжүүд. Бусад хичээлүүдийг төлөвлөж байхдаа тэдгээртэй төстэй санаануудыг бодож ол. (TNGC, 172–175-г үз.)

# Есүс Христ бол миний Аврагч мөн Гэтэлгэгч

Хүүхдийн дууны ном -оос хүссэн дуугаа сонгон дуул.



## Судруудыг цээжлэх

нь хүүхдүүдэд сайн мэдээний сургаалд суралцахад нь тус болдог. Хэрэгцээтэй үед Сүнс тэдгээр үгсийг хүүхдүүдэд сануулдаг. (TNGC, 171–172-г үз.)

**Дуунууд:** Хүүхдийн Хэсгийн дуунууд сайн мэдээний үнэнийг хүүхэд амьдралынхаа туршид санаж байхаар заадаг (TNGC, 172–175-г үз.).



“Христийн Цагаатгалаар дамжин Сайн мэдээний хуулиуд хийгээд ёслолуудад дуулгавартай байснаар бүх хүн төрөлхтөн аврагдана гэдэгт бид итгэдэг” (Итгэлийн тунхаг 1:3).

**Энд дурдах санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд сургаалыг ялган таньж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн Ариун Сүнсийг мэдрэхэд нь би хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.**

## Эхний долоо хоног: Есүс Христ бидний Аврагч байхаар сонгогдсон.

**Сургаалыг ялгаж тань** (үсэгнүүд нийлүүлж): Самбар дээр “Есүс Христ \_\_\_\_\_ бидний Аврагч болох ёстой байсан” гэж бич. С, о, н, г, о, г, д, с, о ба н үсэгнүүдийг өрөөгөөр тараан тавь. Өгүүлбэрийг гүйцээхийн тул тараасан үсэгнүүдийг хүүхдүүдээр цуглуул. Тэднийг Мосе 4:2 дээрээс өөрсдийн хариултыг хянан уншихыг хүс. Самбар дээрх тунхаглалыг хамтдаа унш.

**Ойлгуулахыг хичээ** (дуу дуул): “Би тэнгэрт амьдарч байсан” (ХДН, 4) тухай дараах асуултуудын аль нэгийг бичсэн гурван зурвасыг бэлтгэ:

1. Биднийг дэлхийд ирэхээс өмнө хэн төлөвлөгөөг хүн бүрт танилцуулсан бэ?

2. “Эцэг минь, Таны алдар суу байж болохын тул намайг илгээ” гэж хэн хэлсэн бэ?

3. Эцэгийн төлөвлөгөөг дагаснаар Есүс юуг ялсан бэ?


Дууны эхний бадгийг хүүхдүүдээр дуулуулж, эхний асуултын хариуг дуулахад босохыг хүс. Дараа нь энэ бадгаас тэдний суралцсан зарим зүйлсийн талаар ярилц. Ярилцсаны дараа дахин тэр бадгийг дуулж, тунгаан бод. Дараа нь бусад бадаг болон асуултуудыг хэлэлцэн, үйл ажиллагааг давтан хий.

## Хоёр дахь долоо хоног: Есүс Христ бол миний төгс үлгэр жишээ юм.

**Сургаалыг ялгаж тань** (үлгэр жишээг дагаснаар): Хүүхдүүдээ “Намайг дагаад хий” (CS, 276) дууг дуулж, алгаа таших, гараа дээш сунгах эсвэл дороо алхах зэрэг энгийн үйлдлүүдийг даган хийхийг хүс. Хэн нэгний үлгэр жишээг дагаж сурсан зарим зүйлээсээ нэрлэхийг хүүхдүүдээс хүс (жишээ нь, ороо засах, эсвэл тоглоом тоглох зэрэг). Самбар дээр “Есүс Христ бол миний төгс үлгэр жишээ” гэж бич. Христ бидний дагах ёстой төгс үлгэр жишээг үзүүлэн амьдарч байсан дэлхий дээрх цорын ганц хүн гэдгийг гэрчил. Өгүүлбэрийг хүүхдүүдтэй хамт унш.

**Хэрэгжилтийг урамшуулан дэмж** (санаануудыг хуваалцан): Бусдыг хайрлаж, бусдад үйлчилж байгаа Есүсийн зарим зургийг тавь. Самбарт “Есүс хүн бүрийг хайрласан” мөн “Есүс бусдад үйлчилсэн” гэж бич. Зүрх зурж, эдгээр хэллэгийн дор тавь. Бид бусдыг хайрлаж,

бусдад үйлчилж Есүсийн жишээг дагах ёстой гэдгийг хүүхдүүдэд хэл. Хүүхэд бүрд цаас өгч, зүрх зурж, өөрсдийн гарны дүрсийг буулгаж зурахыг хүс. Дараа нь тэднээс Есүсийн жишээг дагаж чадах ямар нэгэн зүйлийг бичих эсвэл зурахыг хүс. Тэдний санаануудыг Хүүхдийн Хэсэгтэй хуваалцуулж, тэдний цаасыг Есүсийн зургийн дэргэд тавь. “Би Есүс шиг байхыг хүсдэг” (ХДН, 40) дууг дуул.



## Гурав дахь долоо хоног: Христийн Цагаатгалаар дамжин хүн төрөлхтөн аврагдаж чадна.

**Сургаалыг ялгаж тань** (итгэлийн тунхагийг цээжлэн): Хүүхдүүдийг групп болгон хувааж, групп бүрт Итгэлийн Тунхагийн гуравдугаар хэсэг-ээс нэг хэллэг өг. Групп бүрийг зөв дарааллаар нь болгож, өөрсдийн хэллэгийг давтан хэлэхийг хүс. Дараа нь Хүүхдийн Хэсэг бүгд босч, Итгэлийн Тунхагийг бүтнээр нь давтан унших.



**Ойлгуулахыг хичээ** (хичээлтэй холбоотой зүйлийг харуулж): Есүс Христийн Цагаатгал нь биднийг нүглээс авардаг гэдгийг гэрчил. Шилтэй цэвэр ус хүүхдүүдэд харуулж, нүглээс чөлөөлөгдсөн хүн ийм байна гэдгийг тайлбарла. Усны өнгийг өөрчлөх жижиг хүнсний хэсгийг усанд хий. Хүнсний хэсэг хэрхэн усны өнгийг нь өөрчилж, усыг бохирдуулж буйг заа. Нүгэл үйлдэхэд бид энэ ус шиг цэвэр бус болдог гэдгийг тайлбарла. Дараа нь цайруулагчийг усанд дусааж, усыг эргүүлэн цэвэршүүл. Нүглээ наманчлахад Цагаатгал биднийг нүглээс ангижруулан, уучилдаг. Христ Гетсеманид байгаа зургийг үзүүл. Зургийн талаар мэддэг зүйлсийг нь чөлөөтэй хуваалцуул. Есүс Христийн биднийг гэсэн хайр, Түүний бидний нүглийн төлөөх төлөөсийн талаар гэрчил.

### Хэрэгжилтийг урамшуулан дэмж

(наманчлалын талаар ярилу): Энэ товхимолд үзүүлсэн зарим заах аргыг ашиглан хүүхдүүдэд харамсах, уучлахыг гуйх, бурууг зөв болгох, алдаагаа давтахгүй байх зэргийг хамруулсан наманчлалын талаар заа (Хүүхдийн Хэсэг 3, 46–49-г үз).



sharingtime.lds.org дээрээс зураг авч болно.

### Хичээлтэй холбогдолтой зүйлсийг үзүүлснээр хичээл

-ийн сонирхлыг бий болгон, хүүхдүүдийн анхаарлыг төвлөрүүлэх эсвэл сайн мэдээний зарчмыг танилцуулахад ашиглаж болно (TNGC, 164-г үз).  
Гурав дахь долоо хоног дээр өгсөн хичээлтэй холбогдолтой зүйлсээр үзүүлэх хичээлд шаардлагатай материалууд та нарт байхгүй бол өөрсдийн гарын доорх материалуудыг ашигла. Жишээ нь, бохир гарыг савангаар угааж, цэвэр болгож болно.

## Дөрөв дэх долоо хоног: Есүс Христ амилсан, тиймээс би ч мөн амилах болно.

**Ойлгуулахыг хичээ** (судрын түүхүүдээс хуваалцан): Зураг ашиглан Есүсийн үхлийн тухай бяцхан түүхийг ярь (Матай 27:33–60; Марк 15:22–46; Лук 23:33–53; Иохан 19:17–42-г үз). Есүсийн гэр бүл, найз нөхөд нь Түүнийг нас барахад юу мэдэрсэн байж болох тухай бодохыг хүүхдүүдээс хүс. Хэдэн хүүхдээс (эсвэл насанд хүрсэн хүмүүс) урьдчилан Магдалын Мариа болон Христийн Амилалтын

гэрч болсон хэн нэгний тухай түүхээс хуваалцахаар бэлтгэж ирэхийг хүс (Иохан 20:11–18), Петр ба Иохан (Иохан 20:2–10), шавь нар (Иохан 20:19–22; Лук 24:33–53), Томас (Иохан 20:24–29), ба Нифайчууд (3 Нифай 11:8–17-г үз). Хэний тухай түүхээс хуваалцаж байгааг харуулахын тул тэдний энгэрт нэрийг нь зүүж өг.



“Судрын түүхийн хэсгээс үзүүлсэн байхад сайн мэдээний зарчмыг ойлгоход ихэвчлэн хялбар болдог” (TNGC, 55).



**Дуу: “Тэр Хүнийг магъя” дууны 1 ба 3-р бадгийг дуул.**

(Дууны ном, 50-р хуудас)

Гарны хүүхэлдэй харахад энд дар.



**Олон өөр насныхан холилдсон группууд:**

Бага насны болон том хүүхдүүдийг бүгдийг нь хамруулахаар төлөвлө. Жишээ нь, эхний долоо хоногийн хоёр дахь үйл ажиллагаан дээр бага насныхан нэр бүрийг цээжлэхэд нь туслахын тулд та нар хуруун хүүхэлдэй ашиглаж болно. Хоёр дахь долоо хоногийн үйл ажиллагаанд та нар бага насныхныг нэг групп болгон хувааж, багш нар тэдэнд түүхүүдийг ярьж, дараа нь зурагнууд уруу зааж асуулт асууж болно.

Үг ба дүрснүүдийг харахад энд дар.

# Есүс Христийн Сүм сэргээгдсэн

“Гялалзсан өнгө хийгээд алдар сууг нь дүрслэхийн аргагүй хоёр Хүн миний дээр агаарт зогсож байхыг би харав. Тэдний нэг нь надтай ярьж, намайг нэрээр минь дуудан, мөн нөгөөх уруугаа зааж хэлэв—Энэ бол Миний Хайртай Хүү, Түүнийг сонс!” (Иосеф Смит—Түүх 1:17)

Энд дурдах санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд сургаалыг ялган таньж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн Ариун Сүнснийг мэдрэхэд нь би хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.

**Эхний долоо хоног: Есүс Христийн Сүм сэргээгдсэн.**

**Сургаалыг ялгаж тань** (итгэлээс тунхагаас суралцаж): Хүүхдийн Хэсэг эхлэхээс өмнө самбар дээр итгэлийн тунхагийн зургааг бич. Хүүхдүүдээс нүдээ анихыг хүс. Есүс Христийг нас барсны дараа хүмүүс нүгэлтэй болж, Түүний сайн мэдээ ба санваар дэлхийгээс авагдсан. Үүнийг Агуу Урвалт гэж нэрлэдэг ба я л тэдний нүдийг тагласан шиг—хүмүүс Түүний Сүм Иосеф Смитээр дамжуулан сэргээгдэх хүртэл—сүнслэг байдал нь харанхуйд автсан байсан гэдгийг тайлбарла. Анхны үзэгдлийн тухай зургийг өргөж, хүүхдүүдийг нүдээ нээхийг хүс. Хамтдаа чангаар уншиж, итгэлийн тунхагийн зургадугаарыг цээжлүүл. Хэсэг хэсгээр үгийг хасч, бүх үгийг хастал давтан,

хүүхдүүдийг итгэлийн тунхагийг бүрэн цээжилтэл унш.

**Ойлгуулахыг хичээ** (нийлүүлэх тоглоом тоглож): Дараах хүснэгтэнд харуулсан шиг үүргүүдээс оруулан бичсэн зурвас хий. Үүн шиг самбар дээр албан тушаалуудын нэрийг бич. Хүснэгтийн голд үүргийг бичих зай үлдээ. Хүүхдүүдийг таван групп болгон хуваагаад групп бүрт “Үүргүүд” бичсэн зурвасын нэгийг өг. Группуудыг өөрсдийн үг бичсэн зурвасыг самбарт зөв дэс дарааллаар байрлуулахыг хүс. Сэргээгдсэн Сүм нь Есүс Христ дэлхий дээр байхад байсан Сүмийн удирдагчдын адил удирдагчидтай гэдгийг тэмдэглэн хэл.

АНХНЫ СҮМИЙН НЭР	ҮҮРГҮҮД	СЭРГЭЭГДСЭН СҮМИЙН НЭР
Төлөөлөгч	Есүс Христийн онцгой гэрч бай	Төлөөлөгч
Бошиглогч	Тэнгэрлэг Эцэгийн хүслийн дагуу ярь	Бошиглогч
Пастор	Гэгээнтнүүдийн жижиг бүлгийг удирд	Бишоп
Багш	Сайн мэдээг заа	Багш
Евангелист	Онцгой адислалуудыг өг	Патриарх

Үг харахад энд дар.

**Хоёр дахь долоо хоног: Иосеф Смит бол Сэргээлтийн бошиглогч.**

**Ойлгуулахыг хичээ** (судруудын зураг ба түүхүүдээс хуваалцаж): Сүмийн Сэргээлтийн үйл явдлуудыг үзүүлсэн зурагнуудыг цуглуул. “Иосеф Смит бол Сэргээлтийн бошиглогч” гэсэн өгүүлбэрийг өөрт байгаа

зургийн тоогоор хуваа. Тэгээд үг эсвэл хэллэг бүрт зориулсан зурвасыг бэлтгэ (жишээг үз). Хүүхдүүдийг групп болгон хувааж, групп бүрт зурвас, зураг ба зураг дээр юу болж буйг өгүүлсэн судрын эшлэл өг. Хүүхдүүдээр

<p><b>Иосеф</b> ИС—Т 1:5–13</p>	<p><b>Смит</b> ИС—Т 1:14–20</p>	<p><b>бол</b> ИС—Т 1:30–35</p>	<p><b>Сэргээлтийн</b> ИС—Т 1:34–35, 67</p>	<p><b>бошиглогч</b> ИС—Т 1:68–73</p>	<p><b>мөн.</b> С ба Г 109:2–4</p>
---	---	--	--	--	---

судруудаас уншуулж, зурагны талаар харилцан ярилц. Дараа нь групп бүрээс өөрсдийн түүхийг Хүүхдийн Хэсэгтэй хуваалцахыг урь. Үйл явдал бүрт оруулсан Иосеф Смитийн үүргийн тухай ярилц. Тухайн үйл явдал тэдний

амьдралд хэрхэн нөлөөлсөн ба нөлөөлж болох талаар бодохыг хүүхдүүдээс хүс. Зурагнууд болон зурвасыг дарааллынх нь дагуу самбарт байрлуул. Бүх зурвасыг самбарт байрлуулсаны дараа өгүүлбэрийг хамтдаа унш.



**Номны хавчуурга харахад энд дар.**

## Гурав дахь долоо хоног: Мормоны Ном бол Есүс Христийн бас нэгэн гэрээ.

### Ойлгуулахыг хичээ (судруудаас уншиж):

Мормоны Номны эхний хуудсан дахь гарчгийг хамтдаа унш. Дараах судруудыг чангаар унш. Аврагчийн өөр нэгэн нэрийг сонсох бүрд гараа өргөхийг хүүхдүүдээс хүс: 2 Нифай 19:6; Алма 5:38; 3 Нифай 5:26. Хүүхдүүд нэрийг тодотгох бүрд самбар дээр бич. Хэдэн нэрийг сонгож, Аврагч эдгээр үүргүүдийг хэрхэн гүйцэтгэсэн тухай тайлбарла.

### Хэрэгжилтийг урамшуулан дэмж (номны хавчуурга хийж):

Хүүхэд бүрд “Мормоны Ном бол Есүс Христийн бас нэгэн гэрээ” гэж бичсэн номны хавчуурга өг. Номны хавчуургыг чимээд тэдгээрийг өөрсдийн судартаа хэрэглэхийг хүүхдүүдээс хүс. Судраас байнга судлах зуршилтай болох зорилго тавьсан хэдэн хүүхдийн тайланг сонс (Нэгдүгээр сарын хоёр дахь долоо хоногийг хар). Уншсан судрын захиасын тухай мэдрэмжээ хуваалцахыг тэднээс хүсч болно.

## Дөрөв дэх долоо хоног: Санваар сэргээгдсэн.

### Сургаалыг ялган тань (хичээлтэй холбоотой зүйлсийг харж):

Цахилгаанаар цэнэглэгддэг ямар нэгэн зүйлийг хүүхдүүдэд харуул. Дараа нь тэдгээр нь зохих хүчин чадал байхгүй бол ажиллахгүй гэдгийг үзүүл. Өөрийн Төлөөлөгчдийг томилж байгаа Христийн зургийг нэг хүүхдэд бариул. Христийн Сүм санваарын хүчгүйгээр тогтнож чадахгүй гэдгийг тайлбарла. Зураг барьсан хүүхдээс зургаа ардаа нуухыг хүс. Христийн Төлөөлөгчид нас барцаасны дараа санваарын эрх мэдэл алдагдсан гэдгийг тайлбарла. Бас нэг хүүхдээр санваарын сэргээлтийн тухай зургийг бариулан үзүүл. Бурхан Иосеф Смитээр дамжуулан санваарыг сэргээсэн гэдгийг гэрчил.

### Ойлгуулахыг хичээ (тааруулан нийлүүлэх тоглоом тоглож, дуу дуулж):

Хэн нэгэн С ба Г 107:1-г уншиж, санваарын хоёр нэрийг олж сонсохыг хүүхдүүдээс хүс. Самбарт Аароны санваар ба Мелкизедек санваарыг сэргээсэн зургийг байрлуул. Аарон эсвэл Мелкизедек гэж тохирох зураг бүрийн дор бич. Эдгээр санваарыг Иосеф Смитэд хэн сэргээсэн эсвэл эргүүлэн авчирсан тухай

ярилц (Иосеф Смит—Түүх 1:72-г үз). Баптисм, гишүүнээр батлах, ариун ёслол түгээх, ариун ёслол адислах, өвчтөнийг эдгээх зэрэг санваарын ёслолуудын зурагнуудыг хүүхдүүдэд үзүүл. “Санваар сэргээгдлээ” (ХДН, 60) дууг дуулах үедээ зурагнуудыг дамжуулан үзэхийг хүүхдүүдээс хүс. Хөгжмөө гэнэт зогсоож, зураг барьсан хүүхдийг Аарон эсвэл Мелкизедек гэж бичсэн үгсийн хажууд зогсож, тухайн ёслолыг гүйцэтгэх хүчийг үзүүлэхийг хүс. Цаг байвал үргэлжлүүлэн хий.

### Хэрэгжилтийг урамшуулан дэмж

(талархлын зурвас бичиж): Тэднийг санваар хэрхэн адисалсан тухай бодохыг хүүхдүүдээс хүс. Тэднийг өөрсдийн мэдэх санваартанд зориулж (бишоп, багш, аав, эсвэл номлогч зэрэг) талархлын зурвас бичих буюу зураг зурахыг хүс.



### Мэдрэмжээ хуваалцах нь:

Хүүхдүүдэд сайн мэдээний тухай өөрсдийн мэдрэмжээ хуваалцах боломжийг өг. Энэ нь Сүнсийг урьж, өөрсдийн амьдралд сургаалыг хэрхэн хэрэгжүүлэх тухай хүүхдийн ойлголтыг бэхжүүлдэг. (TNGC, 63–65-г үз.)



[Zurguuz.sharingtime.lds.org](http://Zurguuz.sharingtime.lds.org) дээрээс авах боломжтой.

Дөрөв дэх долоо хоногийн үйл ажиллагаан дээр та нар хүүхдүүдийн ойлголтыг шалгах боломжтой. Давтан хийх нь тэдний оюун ухаанд ойлголтыг баттайгаар суулгаж өгдөг.



**Давталт:** Хүүхдүүд давталтаар дамжуулан сурдаг. Итгэлийн зарчмыг дахин баталгаажуулахын тулд эхний долоо хоногийн хичээлтэй холбоотой зүйлс үзүүлэх асуудлыг улам дэлгэрэнгүй болгох тухай бодож үз. Саванд үр суулгаж, цаашдаа Хүүхдийн Хэсэгт нахиалан ургах суулгацаа авчирч үзүүл. Та ургамал ургахад туслан юу хийснээ хүүхдүүдэд хэл. Үрийг арчлах Есүс Христэд итгэх итгэлээ арчлах хоёрыг харьцуул.


# Сайн мэдээний анхны зарчим ба ёслолууд нь намайг Бурхантай дахин амьдрах боломжтой болгодог

“Сайн мэдээний анхдагч зарчмууд хийгээд ёслолууд нь: нэгдүгээрт, Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл; хоёрдугаарт, Наманчлал; гуравдугаарт, Нүглүүдийн ангижралын төлөөх усанд умбуулах баптисм; дөрөвдүгээрт, Ариун Сүнсний бэлгийн төлөөх гар тавилт гэдэгт бид итгэдэг” (Итгэлийн Тунхаг 1:4).

Энд дурьдах санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд сургаалыг ялган таньж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн Ариун Сүнсийг мэдрэхэд нь би хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.

**Эхний долоо хоног: Есүс Христэд итгэх итгэл нь Түүнийг хайрлах, Түүнтэй хамт амьдрах, Түүнд итгэх мөн Түүний зарлигуудыг сахихад биднийг хөтөлдөг.**

**Сургаалыг ялган таньж, ойлгуулахыг хичээ** (хичээлтэй холбоотой зүйлийг үзүүлж мөн дуу дуулж): Самбар дээр “Есүс Христэд итгэх итгэл нь Түүнийг хайрлах, Түүнтэй хамт амьдрах, Түүнд итгэх мөн Түүний зарлигуудыг сахихад биднийг хөтөлдөг” гэж бич. Хүүхдүүд зарим үр үзүүл. “Энэ үрнүүд ямар болох вэ?” “Эдгээр үр ургана гэдгийг та нар хэрхэн мэддэг бэ?” Эдгээрийг ургуулахын тулд бид юу хийх ёстой вэ?” гэж асуу. Есүс Христэд итгэх бидний итгэл яг энэ үртэй адил хэрэв бид түүнийг арчлах юм бол ургана гэдгийг тайлбарла. Итгэлээ өсгөхийн тулд бидний хийж чадах зүйлсийн талаар ярилц. Эдгээр зүйлс биднийг хэрхэн Есүс Христийг хайрлах, Түүнд итгэх мөн Түүний зарлигуудыг сахих явдал уруу хөтлөх тухай тайлбарла. “Итгэл” (ХДН, 50) дууг дуул. Эхний бадгийг дуулахдаа гараараа энгийн хөдөлгөөнүүдийг зохион хий.



Зургууг [sharingtime.lds.org](http://sharingtime.lds.org) дээрээс авах боломжтой.

**Хоёр дахь долоо хоног: Наманчлал нь уучлалыг авчирдаг.**

**Сургаалыг ялгаж тань** (судруудаас уншиж): Хүүхдүүдийг судраа нээж, Сургаал ба Гэрээ 58:42–43-г уншихыг хүс. Өөрсдийн нүглийг наманчлахад юу тохиолддог тухай таньж мэдэхийг тэднээс хүс. (Хэрэв боломжтой бол хүүхдүүдийг судар дээрээ эдгээр шүлгийг тодруулан тэмдэглэхийг хүс) Иносын тухай товчхон хуваалц (Инос 1:1–4), нэг хүүхдээр Инос 1:5–8-г уншуул. Христийн Цагаатгал нь биднийг нүглээсээ ангижрах боломжтой болгодог гэдгийг гэрчил.

**Ойлгуулахыг хичээ** (дүрслэн тогло): Наманчилсан хүмүүс өөрсдийн нүглээс уучлагдаж,

Бурханд үйлчлэх хүсэлтэй болдог гэдгийг тайлбарла. Хүүхдүүдийг гурван групп болгон хувааж, групп бүрт дараах зураг ба судрын эшлэлүүдийг өг: Алма Мормоны усанд баптисм хүртээсэн нь (Мозая 17:2–4; 18:1–17); Иона (Иона 1–3); Антай-Нифай-Лихайчууд өөрсдийн сэлмийг булсан нь (Алма 23:4–18; 24:6–19). Эдгээр түүхүүд нь өөрсдийн нүглийг наманчилж, Их Эзэнд үйлчилсэн хүмүүсийн тухай хэлдэг гэдгийг тайлбарла. Групп бүр судруудыг дахин уншиж, эдгээр хүмүүс хэрхэн наманчилж, дараа нь Их Эзэнд үйлчилсэн тухай дүрслэн үзүүлэх тоглолт бэлтгэн үзүүлэхийг хүс.

## Гурав дахь долоо хоног: Баптисм хүртсэнээр би Бурхантай гэрээ хийдэг.

**Ойлгуулахыг хичээ** (*хичээлтэй холбоотой зүйлийг харж*): Нэг хүүхдийг ангийн өмнө урин гаргаж, гараа өргөн зогсохыг хүс. Тэгээд хоёр гарт нь ном бариул. Мозая 18: 7–11-г унш. Бид баптисм хүртэх үедээ хийдэг гэрээнүүдийн нэг бол “нэг нэгнийхээ ачааг хөнгөлөхийн тулд үүрэлцэхэд бэлэн байх” гэдгийг тайлбарла. Ном өргөсөн хүүхдийн гар нь чилж байгаа эсэхийг асуу. Хоёр хүүхдийг урьж, түүний гарыг түшиж туслахыг хүс. Элэглэн шоолох, өвдөх, гарцаардах эсвэл сургууль дээрээ асуудалтай байх зэрэг хүүхдүүдтэй учирч болох бусад ачаануудын талаар ярилц. Бид хэрхэн нэг нэгнийхээ ачааг хөнгөлж чадах тухай тэднээс асуу.

**Хэрэгжилтийг урамшуулан дэмж** (*тоглоом тогло*): Баптисм нь мөнхийн амьдрал уруу хөтлөх хаалга гэдгийг хүүхдүүдэд хэл (2 Нифай 31:17). Баптисм хүртэж байгаа хүүхдийн зургийг өрөөний нэг талд байрлуул. Өрөөний

нөгөө талд Аврагчийн зургийг тавьж, Аврагчийн зураг мөнхийн амьдралыг төлөөлж буйг хэл. Баптисмынхаа гэрээг сахиснаар мөнхийн амьдралд хүрэх зам дээрээ үлддэг гэдгийг хүүхдүүдэд хэл. Гэрээнүүдийг товчхон эргэн сануул (Есүс Христийг санаж, зарлигуудыг сахиж, бусдад туслах). Хүүхэд бүрд ЗС бамбайг зурсан цаас өг.

Цаасан дээр баптисмын гэрээнүүдээ сахихад нь туслах нэг зарлиг бичихийг хүүхдүүдээс хүс (өөрсдийн сонгосон зарлигийг тэд зурж болно). Шалан дээр хоёр зургийн дунд өөрийн бичсэн зарлигийг байрлуулахыг хүс. Хэрэв боломжтой бол судраас тэдний бичсэн зарлигуудыг олоход нь тусалж, хамтдаа унш. Хүүхэд бүр зурагнуудын дунд зам хийх хүртэл үргэлжлүүлэн хий.



**Лого харахад энд дар.**



*Хүүхдүүдийг үзүүлэн болгох нь тэдний анхаарлыг төвлөрүүлж, суралцахад нь бэлтгэж өгдөг. Жишээ нь, энэ үйл ажиллагаа нэг нэгнийхээ ачааг үүрэлцэх тухай ойлголтыг хүүхдэд үзүүлж байна.*

## Дөрөв дэх долоо хоног: Ариун Сүнс биднийг тайвшруулж, удирдан залдаг.

**Ойлгуулахыг хичээ** (*судруудаас уншиж*): Хүүхдүүдийг групп болгон хуваа. Групп бүрт дараах судартай цаас өг:

- “Үнэнээр, үнэнээр, би чамд хэлнэ, оюуныг чинь гэгээрүүлж, сүнсийг чинь баяраар дүүргэх Сүнснээсээ би чамтай хуваалцах болно \_\_\_\_\_” (С ба Г 11:13).
- “Хэрэв та нар уг замд [баптисм] орох мөн Ариун Сүнсийг хүлээн авбаас, энэ нь \_\_\_\_\_ та нарын хийвэл зохих тэр бүх зүйлийг та нарт үзүүлэх болно” (2 Нифай 32:5).
- “Туслагч буюу Миний нэрээр Эцэгийн минь илгээх \_\_\_\_\_ Ариун Сүнс бүх зүйлсийг заах бөгөөд \_\_\_\_\_ Миний та нарт хэлсэн бүгдийг сануулах болно” (Иохан 14:26).
- “Шударгаар үйлдэхэд, даруухнаар алхахад, \_\_\_\_\_ зөв шударгаар шүүхэд хөтөлдөг \_\_\_\_\_ тэр Сүнсэнд итгэлээ тавигтун” (С ба Г 11:12).

- “Ариун Сүнсний хүчээр та нар бүх зүйлийн \_\_\_\_\_ үнэнийг мэдэж болно” (Моронай 10:5).

Судруудыг харж, хоосон зайг бөглөхийг хүүхдүүдээс хүс. Дараа нь Ариун Сүнс бидэнд хэрхэн тусалдаг тухай эдгээр судруудад юу гэж заасныг ярилц. Ариун Сүнс тэдэнд тусалсан тухай туршлагаасаа хуваалцахыг тэднээс хүс.

**Хэрэгжилтийг урамшуулан дэмж** (*дуу дуулж*): Ариун Сүнс олон арга замаар бидэнд тусалдгийг хүүхдүүдэд хэл. “Ариун Сүнс” (ХДН, 56) дууг дуул. Ариун Сүнс тэдэнд туслах арга замуудын тухай дуулах бүрт гараа өргөхийг хүүхдүүдээс хүс. Дуулахаа зогсоож, Ариун Сүнсний тухай тэд юу сурч мэдсэнийг ярилц. Дуулж, ярилцах үйлдлээ үргэлжлүүлэн хий. Ариун Сүнс тайвшруулсан эсвэл чиглүүлсэн тохиолдлоосоо хуваалц.

**Тараах материал харахад энд дар.**

**Судрууд:** Судруудаас унших нь хүүхдүүд сайн мэдээний зарчмуудыг суралцахад чухал ач холбогдолтой (TNGC, 50–51-г үз). Таныг судраас чангаар унших үед үг бүрийг давтан хэлэхийг хүүхдүүдээс хүс. Бага насны хүүхдүүдийг нэгэн сонгосон үг эсвэл хэллэг гарах бүрд гараа өргөхийг хүс.

Дуу: “Би Ариун сүм харах дуртай” (ХДН, 99)



Дүрснүүдийг [sharingtime.lds.org](http://sharingtime.lds.org) дээрээс авах боломжтой.

### Хариултуудыг хэлүүлж:

Хэрэв хүүхдүүдэд бодох хугацааг өгөх юм бол тэд асуултанд хариулж чадахад дөхөм байх болно. Хариултыг авахын өмнө тэдэнд бодох хугацаа өгнө гэдгийг хэл. (TNGC, 69-г үз.)

Зааж буй сургаалаа тодорхой ялган таниул. Ингэснээр хүүхдүүд үүнийг илүү сайн ойлгож, илүү сайн хэрэгжүүлэхэд нь дөхөм болно.

Үг харахад энд дар.

# Ариун Сүм бол Бурханы Өргөө

“Ариун нандин ёслол, гэрээг Ариун Сүмүүдэд гүйцэтгэдэг нандин ёслол ба гэрээнүүд нь хувь хүмүүс Бурханы хүрээлэлд эргэн очих, гэр бүлүүд мөнхөд нэгдэх боломжтой болгодог ариун сүмд үйлддэг учраас хувь хүн Бурханд эргэн очиж, нэг гэр бүлийнхэн мөнхөд хамт байх боломж олддог” (“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг” догол мөр 3)

Энд дурдах санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд сургаалыг ялган таньж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн Ариун Сүнснийг мэдрэхэд нь би хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.

## Эхний долоо хоног: Бурхан Өөрийн хүмүүст ариун сүмүүд барихыг тушаасан.

**Сургаалыг ялгаж тань (дуу дуулж):** Ариун сүмийн зургийг үзүүлж, самбар дээр “Ариун сүм бол \_\_\_\_\_” гэж бич. “Би Ариун сүм харах дуртай” (ХДН, 99) дууны эхний бадгийг дуулахыг хүүхдүүдээс хүс. Самбар дээрх өгүүлбэрийг дуусгах хэллэгийг дуулах үед тэд гараар дохио өгөхийг хүс. Ариун сүм (Бурханы өргөө) нь юу болохыг тэднээс асуу. Хүүхдүүдэд Судруудын удирдамж дээр “Ариун сүм” (20–21-р хуудас) гэснийг харахад нь тусал. Ариун сүм нь үгчлэн хэлбэл, Их Эзэний өргөө ба ариун сүмүүд барихыг Их Эзэн Өөрийн хүмүүст байнга зарлигладаг гэсэн тунхаглалыг олоход нь тэдэнд тусал.

**Ойлгуулахыг хичээ (таах тоглоом тоглож):** Мосе (Египетээс Гарсан нь 25:1–2, 8–9), Нифай (2 Нифай 5:16), ба Иосеф Смит (С ба Г 124:31) болон тэдний дагалдагчдын барьсан ариун сүмийн талаарх түлхүүр өгүүлбэрийг бэлтгэ.

## Хоёр дахь долоо хоног: Гэр бүлүүд ариун сүмийн нандин ёслолуудаар дамжуулан адислагддаг.



**Сургаалыг ялгаж тань (үсэгнүүд нийлүүлж мөн дуу дуулж):** Ахлах насны хүүхдээр “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-ийн 3-р догол мөрний сүүлийн хоёр өгүүлбэрийг уншуул. Дараах үгс ба хэллэгийг тус тусад нь өөр өөр цаасан дээр бич: Ариун сүм бол, бид, лацдан холбогдох, ариун нандин газар. Самбарт замбараагүй дарааллаар байрлуул. Нэг хүүхдийг урьж, зөв байрлалд оруулахыг хүс. Өгүүлбэр зөв байрлалдаа ортол үргэлжлүүлэн хий. “Би ариун сүм харах дуртай” дууны хоёр дахь бадгийг дуулж, хүүхдүүдийн хагас нь бид ариун сүмд хийдэг хоёр зүйлийг (гэрээ ба дуулгавартай байх амлалт), нөгөө хагасыг сурсан үнэнийг (гэр бүл бол үүрдийнх) олж сонсохыг хүс. Ариун сүмд гэр бүлтэйгээ лацдан холбогдоно гэдэг тэд үүрд хамтдаа байна



гэсэн утгатай болохыг хүүхдүүд ойлгоход нь тусал.

**Хэрэгжилтийг урамшуулан дэмж** (*мэд-рэмжээсээ хуваалцаж, зураг зурж*): Нэг гэр бүл эсвэл хэдэн хүүхдийг ариун сүмийн талбайд

очоод мэдэрсэн мэдрэмж, ариун сүмийн болон лацдан холбогдох ёслолуудын учир тэд хэрхэн адислагдсан тухай мэдрэмжээ хуваалцахыг хүс. Гэр бүлээрээ Ариун сүмийн гадна байгаа зураг зурахыг хүүхдүүдээс хүс.

### **Зааж байгаа хүмүүсээ хайрла:**

*Мөнхийн гэр бүлийн тухай зааж байхдаа эцэг эхгүй өнчин хүүхдүүдэд болгоомжтой мэдрэмжтэй хандаарай. Мөн Сүмийн гишүүн бус эсвэл эцэг эх, ахан дүүс нь сүмд идэвхгүй болсон хүүхдүүдэд мэдрэмжтэй хандаарай. Бүх хүүхдүүдийг нэгэн өдөр өөрсдийн мөнхийн гэр бүлүүдтэй болохоор зохистой амьдрахыг урамшуулан дэмж. (TNGC, 31–32-г үз.)*

## **Гурав дахь долоо хоног: Анхдагчид ариун сүмийг барихын төлөө шаргуу ажиллаж, золиослолыг хийсэн.**

**Ойлгуулахыг хичээ** (*хүмүүсийг урьж сонсох*): Көртланд ба Солт Лейкийн ариун сүмийн эсвэл боломжтой бол ойролцоох ариун сүмийнхээ баригдсан тухай мэдээллийг цуглуул. (Хүүхдийн Хэсэг 5, 25 ба 44-р хичээл эсвэл LDS.org дээрээс Көртланд ба Солт Лейкийн ариун сүмийн тухай мэдээлэл ав.) Насанд

хүрэгчдийг Хүүхдийн Хэсэгт ирж, хүүхдүүдтэй мэдээлэл хуваалцахыг хүс. Хүүхдүүдийг групп болгон хувааж, насанд хүрэгч бүртэй группээр ээлжлэн уулз. Нэг зочноос нөгөөд шилжин явахдаа “Би ариун сүм харах дуртай” дууг дуулахыг хүс.



*Өөрийн Хүүхдийн Хэсгийн хэрэгцээнд зохицуулан үйл ажиллагаануудыг сонго. Жишээ нь, хэрэв том Хүүхдийн Хэсэгтэй бол хүүхдүүдийг хөдөлгөхийн оронд ирсэн зочныг группээс группэд аялуулан яриулж болно (TNGC, 179-г үз).*

## **Дөрөв дэх долоо хоног: Би ариун сүмд орохоор зохистой байхад бэлтгэж чадна.**

**Ойлголт ба хэрэгжилтийг чухалчил** (*бусадтай ярилцаж мөн бусдад зааж*): “Сайн мэдээний миний жишгүүд”-ийг үзүүлж, эдгээр жишгүүдийг дагах нь ариун сүмд орохоор зохистой байхад бидэнд тусалдаг гэдгийг тайлбарла. Хүүхдүүдийг групп болгон хуваа. Нэг багш групп бүртэй хүүхдүүдийг ариун сүмд орохоор зохистой байхад туслах жишгүүдийн талаар ярилцаж, жишгүүдийн дагуу амьдрах нь түүнд хэрхэн тусалсан тухай гэрчил. Групп бүрийг



сайн мэдээний жишгүүдээс нэгийг сонгож, тэр жишгийг дагах өөрсдийн амлалтыг бичих буюу зурахыг хүс. Бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчийг Хүүхдийн Хэсэгт урь. Групп бүр өөрсдийн амлалтыг түүнтэй хуваалц. Ариун сүмийн чухал ач холбогдлын тухай өөрсдийн гэрчлэлийг хуваалцахыг бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчөөс хүс.

**Зурагт хуудас харахад энд дар.**

**Жилийн уриа:** *Судраас уншиж суралцсан зүйлсээсээ хуваалцах боломжийг хүүхдүүдэд өгөхөө санаарай (нэгдүгээр сарын хоёр дахь долоо хоногийг хар).*

# Миний бие бол Бурханы Ариун сүм

Дуу: “Их Эзэн надад ариун сүм өгсөн” (ХДН, 73)



**Хуулбарууд:** Хэрэв та нарт олшруулах машин байхгүй бол үзүүлэнгийн дээр цулгүй цаас тавих эсвэл LDS.org дээрээс хэвлэн авч болно.

Хүүхдийн Хэсгийнхээ хэрэгцээнд тохируулан (TNGC, 110–117-г үз) үйл ажиллагаануудыг хялбаршуулан ашигла. Жишээ нь, хоёр дахь долоо хоногийн хоёр дахь үйл ажиллагааг томоохон Хүүхдийн Хэсэгтэй хийхдээ асуулт асууж, хүүхэд бүрийг жишжиг цаасан дээр нэг санааг бичих эсвэл зурахыг хүсч болно. Дараа нь үзүүлэнд хүүхдүүдийн цаасыг нэмж бэхэл.

“Та нар өөрсдөө Бурханы сүм мөн бөгөөд Бурханы Сүнс та нарын дотор оршдог гэдгийг мэддэггүй юм уу? . . . Бурханы сүм бол ариун бөгөөд энэ нь та нар мөн” (1 Коринт 3:16–17).

Энд дурдах санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд сургаалыг ялган таньж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн Ариун Сүнсийг мэдрэхэд нь би хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.

## Эхний долоо хоног: Миний бие бол ариун сүм.

**Сургаалыг ялгаж тань** (ариун сүмийн тухай ярилцаж): Хүүхдийн Хэсэг эхлэхээс өмнө самбар дээр “Та нар Бурханы сүм” (1 Коринт 3:16) гэж бич. Ариун сүмүүдийн зургийг хүүхдүүдэд үзүүл. Ариун сүмийн онцгой байдлын талаар асуу (энэ нь Их Эзэний өргөө, цэвэрхэн, маш сайн арчилдаг, Ариун Сүнс оршдог газар). Хариултыг самбарт бич. Бидний бие махбод яг ариун сүмийн адил ариун нандин бөгөөд өөрсдөө болон бусад хүмүүс түүнд хүндэтгэлтэй хандах ёстой гэдгийг тайлбарла.

### Ойлголт ба хэрэгжилтийг чухалчил

(асуултанд харуулж, зураг будаж): Нярайн ангийн гарын авлагын Behold Your Little Ones 47-р хуудсан дээр байгаа зургийг хуулж ав. Зурган дээрх дугуйнуудыг хайчилж аваад, саванд хий. Нэг дугуйг хүүхдээр сонгуул. Өөрсдийн биеийг ариун сүмийн адил авч явах ёстойг зураг тэдэнд хэрхэн сануулж



буйг хүүхдүүдээс асуу. Хүүхэд бүрд зураг өгч, будуул. Ахмад хүүхдүүдийг дугуй бүрийн дор энэ долоо хоногт өөрсдийн биеийг ариун сүмийн адил авч явах нэг зүйл бичихийг хүс. Зурагнуудаа гэртээ авч хариад, өөрсдийн гэр бүлдээ биеэ хэрхэн ариун сүмийн адил авч явах тухай заахыг хүс.



### Хэрэгжилтийг урамшуулан дэмж

(сайн мэдээний жишгүүдийн тухай ярилцаж): “Сайн мэдээний миний жишгүүд” –ийг үзүүл. Өөрсдийн биеийг ариун сүмийн адил авч

явах тухай сайн мэдээний ямар жишгүүд заадаг тухай тодруулахыг хүүхдүүдээс хүс. Хажууд буй хүүхэд бүртэйгээ өөрсдийн биеийг ариун сүмийн адил авч явах тухай нэг арга замыг хуваалцахыг тэднээс хүс. Дараа нь өөрийгөө хөгжүүлэх нэг арга замын талаар бодохыг хүүхдүүдээс хүс. Хэсэг хүүхдүүдийг урьж, бусадтай бодол санаагаа хуваалцахыг хүс.

**Зурагт хуудас ба нярайн гарын авлага харахад энд дар.**

## Хоёр дахь долоо хоног: Даруу хувцаслалт нь Тэнгэрлэг Эцэг ба өөрийгөө хүндэтгэж буйг харуулдаг.

**Сургаалыг ялгаж тань** (судар ба сайн мэдээний жишгээс уншиж): Хүүхдүүдийг 1 Коринт 3:16 –г нээж, хамтдаа чангаар уншихыг хүс. Өөрсдийн биеийг ариун сүмийн адил авч явах нэг арга зам бол даруу хувцаслалт гэдгийг хүүхдүүдэд хэл. “Сайн мэдээний миний жишгүүд”-ийг үзүүлж, “Би Тэнгэрлэг Эцэгтээ болон өөртөө хүндэтгэл үзүүлж даруухан хувцаслана” гэдгийг хамтдаа чанга унш.

### Ойлгуулахыг хичээ

(даруу байдлын тухай ярьж, тайлбар зураг үзүүлэн үзүүлж): Даруу хувцаслалт гэж ямар утгатай болохыг ярилц (Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө –гийн “Хувцаслалт ба Гадаад Төрх” хэсгийг үз). “Би . . .

даруу хувцаслах болно” гэж дээр нь бичсэн хэдэн үзүүлэн бэлтгэ. Хүүхдүүдийг групп болгон хувааж, групп бүрийг өөрсдийн амлалтыг бичих юм уу аль нэгэн үзүүлэн дээр даруу хувцастай өөрийн зургийг зурахыг хүс. Хүүхдийн Хэсгийн ангид үзүүлэнгүүд тавь.



## Гурав дахь долоо хоног: Мэргэн Ухааны үгээр амьдарч өөрсдийн даруу байдлаа харуулдаг.

### Ойлгуулахыг хичээ (судруудаас уншиж):

Самбарын нэг талд “Зарлигууд” гэж бичээд дараах судрын эшлэлийг бич: С ба Г 89:7–9, 12, 14, 16. Нөгөө талд нь “Амлалтууд” гэж бичээд дараах судрын эшлэлийг бич: С ба Г 89:18–21. Ангийн тал нь судрын эхний хэсгийг уншиж, Мэргэн Ухааны үг дээрх Их Эзэний өгсөн зарлигуудыг олуул. Нөгөө хагас нь судруудыг уншсан хэвээр байж, бид дуулгавартай байх аваас хүртэх Түүний амласан адислалуудыг

### МЭРГЭН УХААНЫ ҮГ

#### Зарлигууд

С ба Г 89:7–9, 12, 14, 16

#### Амлалтууд

С ба Г 89:18–21

олуул. Зарлиг болон адислалууд гэдэг юу гэсэн үг болох тухай ярилц.

**Хэрэгжилтийг урамшуулан дэмж (тоглоом тоглож):** Нэг хүүхдээр “Би . . . байж, Мэргэн Ухааны үгээр амьдрах болно” гэж хэлүүлж, \_\_\_\_\_ Мэргэн Ухааны үгээр амьдрах ямар нэгэн зүйлээр хоосон зайг бөглүүл. Дараа нь өөр нэгэн хүүхдээр хэллэг ба эхний хүүхдийн хариултыг давтан хэлүүлж, өөрийнх нь хариултыг нэм. Гурав дахь хүүхдээр хэллэг ба өмнөх хоёр хүүхдийн хариултыг давтан хэлүүлж бас нэгэн хариултыг нэм. Хүүхэд бүрийн хариултыг авч дуустал хичээлийн цагтаа багтаан, үргэлжлүүлэн хий.



Зурагнуудыг [sharingtime.lds.org](http://sharingtime.lds.org) дээрээс авч болно.

## Дөрөв дэх долоо хоног: Ашиг тустай эрүүл сайн сайхан зүйлсийг уншиж, үзэж, сонсох нь миний оюун ухааныг цэвэр байлгадаг.

**Сургаалыг ялгаж тань (хичээлтэй холбогдолтой зүйлсийг үзүүлж):** Хоёр шилэн аяганы нэгэнд нь бохир ус, нөгөөдөхөд нь цэвэр ус хийж хүүхдүүдэд үзүүл. Хүүхдүүдээс аль аягатай усыг уухыг болон яагаад тэгэхийг нь асуу. Бидний оюун ухаан шилэн аягатай адил бөгөөд бид зөвхөн цэвэр, сайн зүйлсийг түүн уруу хийх ёстой гэдгийг хүүхдүүдэд хэл. Самбарт дараах өгүүлбэрийг бич. Түүнийг даган хэлэхийг хүс: “Ашиг тустай эрүүл сайн сайхан зүйлсийг уншиж, үзэж, сонсох нь миний оюун ухааныг цэвэр байлгадаг.” Өгүүлбэрийг цээжлүүлэхийн тулд энгийн гарын хөдөлгөөнийг ашиглан заа. Жишээ нь, унших гэдэг үгийг хэлэхэд ном барьж байгаа мэт гараа барь, үзэх гэхэд нүдээ заа; сонсох гэхэд хоёр гараа чихэн дээрээ аваач, оюун ухаан гэхэд толгой

уруугаа заа. Өгүүлбэрийг гарын хөдөлгөөнийг оролцуулан хэд дахин давтан хэл.

**Ойлгуулахыг хичээ (тоглоом тоглож, дуу дуулж):** Есүс Христ хүүхдүүдтэй байгаа зургийг хүүхдүүдэд үзүүлж, хэсэг хугацаанд зураг дээр анхаарлаа төвлөрүүлэн харахыг хүс. Зургийг хааж, хүүхдүүдээс санаж байгаа тодорхой зүйлсээс хэлэхийг хүс. Бид юмыг харж тогтоодог гэдгийг хүүхдүүд ойлгоход нь тусал. Бид оюун ухаанаа сайн зүйлсээр дүүргэвэл мөн сайн сайхан зүйлсийн талаар боддог гэдгийг тайлбарла. Зураг үзүүлж, “Би Аврагчийн хайрыг мэдэрдэг” (ХДН, 42) дууг дуул. Дуу тэдэнд ямар сэтгэгдэл төрүүлж буйг асуу. Сайн дуу хөгжим сонсох нь Сүнсийг мэдрэхэд бидэнд тусалдаг ба оюун ухааныг цэвэр байлгадаг.



Олон төрлийн заах арга замыг ашиглах нь хүүхдүүдийг илүү үр дүнтэй суралцахад нь тусалдаг. Жишээ нь, дөрөв дэх долоо хоногт хичээлд холбоотой зүйлийг хүүхдүүд хараад сургаалыг таньж, дараа нь энгийн гарын хөдөлгөөнийг ашиглан тэдгээрийг санаж үлдэхэд нь тусал.

# Сайн мэдээ дэлхий дахинд номлогдсон байх болно

“Сайн мэдээ бүх үндэстэн, мөн ястан мөн хэлтэн хүмүүст номлогдох болно”  
(С ба Г 133:37).

Энд дурдах санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд сургаалыг ялган таньж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн Ариун Сүнснийг мэдрэхэд нь би хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.

**Зурж:** Эхний долоо хоногийн газрын зургийг зурж, хэвлэж, эсвэл гэрээсээ авчирч болно. Хэрэв та зурахаар төлөвлөсөн бол зурах дасгалаа урьдчилан хий. Зурах авъяасгүй байдлын төлөө уучлалт гүйх хэрэггүй. Уучлалт хүсэх нь зөвхөн тухайн зурагт тавих анхаарлыг нь сарниулах болно. Хэрэв та нар зурахаас төвөгшөөж байгаа бол хэн нэгнийг туслахыг хүс (TNGC, 162–163-г үз).



## Хайраа харуул:

Хүүхэд бүрт хайраа харуулах боломжийг эрэлхийл. Зааж байгаа хүүхдүүддээ хайраа харуулвал тэд илүү ихээр Сүнснийг мэдэрч, сурч байгаа зүйлдээ илүү идэвхтэй байх болно (TNGC, 31-г үз).

## Эхний долоо хоног: Сайн мэдээ дэлхий дахинд номлогдсон байх болно гэж судруудад заадаг.

### Сургаалыг ялгаж тань (судар уншиж):

Ахмад хүүхдээр Сургаал ба Гэрээ 133:37 –г чангаар уншуул. Дэлхийн олон газарт, олон янзын хэлээр номлогчид сайн мэдээг заадаг гэдгийг хүүхдүүдэд хэл. Хүүхдүүдийг хамтаар нь судраас даган уншуул.

### Ойлгуулахыг хичээ (номлолын талаар ярьж):

Дэлхийн газрын зургийг хүүхдүүдэд үзүүл эсвэл самбар дээр дэлхийн газрын зураг зур. Таньдаг хүмүүсийнхээ номлолд үйлчилсэн газруудыг тоочихыг тэднээс хүс. Тэдгээр газруудыг газрын зураг дээрээ тэмдэглэ. Тэд хаана номлолд үйлчлэхийг хүсч байгааг нь асуу. Тэдгээр газруудыг газрын зураг дээр тэмдэглэхийг тэднээс хүс. Номлолын дуудлага нь бошиглогчоор дамжин Их Эзэнээс ирдэг ба хаана ч байсан номлогчид Их Эзэний дуудсан газар үйлчилдэг гэдгийг тайлбарла. Сүмийн нэрийг өөр хэлнүүд дээр хэлэхэд нь тусал. Номлогчид заах зөвшөөрөл хараахан олгогдоогүй газар байдаг талаар хүүхдүүдтэй ярилц. Томас С.Монсон “бид [хүн бүр]-тэй сайн мэдээний баяр баясгаланг хуваалцаж болохын тулд тэдгээр газрууд нээгдэхийн төлөө залбирахыг” биднээс хүссэн (2008 оны 10-р сар, 4; эсвэл *Ensign*, 2008 оны 11-р сар, 6).

**Хэрэгжилтийг урамшуулан дэмж (номлогчдод захидал бичиж):** Тойргоос чинь гарсан эсвэл тойрогт чинь үйлчилж байгаа бүрэн цагийн номлогчдод зурвас бичихийг хүүхдүүдээс хүс. Захидлыг номлогчдод илгээхээр тойргийнхоо номлолын удирдагчид өг.



Энэ үйл ажиллагаанд зөвхөн цөөхөн хүүхдийг ангийн өмнө гаргах хэрэгтэй. Бүх хүүхдүүдийг оролцуулахын тулд хажуудах хүүхдэдээ хаана үйлчлэх хүсэлтэй байгаагаа шивнэн хэлэхийг хүс.

**Газрын зураг харахад энд дар.**

## Хоёр дахь долоо хоног: Номлолын ажил хүн бүрийг адисалдаг.

### Ойлгуулахыг хичээ (зочны хэлэх үгийг сонсож):

Буцаж ирсэн номлогчийг Хүүхдийн Хэсэгтэй урьж, номлолын ажлыг хийснээр хүлээн авсан зарим адислалуудаас нь хуваалцуул. Бусад хүмүүсийг (шинэ хөрвөгч,

хүүхдүүд эсвэл гэр бүлүүд) урьж, тэдний амьдралыг номлолын ажил хэрхэн адисалсан тухай хуваалц. Хүүхдүүдийг “Бид энэ дэлхийд Түүний үнэнийг авчирна” (ХДН, 92) дууг зочинд дуулж өгөхийг хүс.

## Гурав дахь долоо хоног: Би одоо номлолд үйлчлэхээр бэлдэж чадна.

### Ойлгуулахыг хичээ (судруудаас уншиж):

Аммоны зургийг үзүүлж, тэр Леменчүүдэд сайн мэдээг заасан агуу номлогч байсан гэдгийг хүүхдүүдэд хэл. Тэр номлолд явахаасаа өмнө номлогч байхаар бэлтгэгдсэн гэдгийг тайлбарла. Алма 17:2–3 –г чангаар унш (эсвэл ахмад хүүхдээр уншуул). Бусад хүүхдүүд сонсож, Аммоны номлогч байхаар бэлтгэгдсэн тухай уншигдахад гараа өргөхийг тэднээс хүс. Нэг хүүхдээр тэдний хариултуудыг самбар дээр бичүүл. Тэд номлогч байхаар бэлтгэхдээ үүнтэй ижил зүйлсийг хийж болно гэдгийг хэл. “Тэд намайг номлолд дуудна гэж найдаж байна” (ХДН, 91) дууг дуул. Дуулахдаа хаалга тогших, судруудаас унших эсвэл

дугуй унах зэрэг номлогчдын хийдэг энгийн үйлдлүүдийг үзүүлэхийг хүс.

**Хэрэгжилтийг урамшуулан дэмж (номлолд бэлтгэж):** Судруудаас судлах, гэрчлэлтэй болох, зарлигуудыг дагах, аравны нэгээ төлөх, мөнгө хадгалах зэрэг номлогч байхад одооноос бэлтгэж болох зүйлс байдгийг хүүхдүүдэд хэл. Хүүхэд бүрт аравны нэгийн хуудсыг өгч, түүнийг хэрхэн бөглөхийг үзүүл. Аравны нэгийн болон өөрсдийн номлолдоо хадгалж байгаа мөнгөө хураах онцгой газрыг бэлтгэхэд нь тусал. Энэ нь хайрцаг, жижиг шил юм уу лааз, эсвэл аравны нэг болон хадгаламжинд зориулсан онцгой дугтуй байж болно.



Зургууз sharingtime.lds.org дээрээс авах боломжтой.



Самбар дээр нэг хүүхдээр түүнийг үнэ цэнэтэй болгох зүйлсээс бичихийг хүс. Энэ нь бусад хүүхдүүдийн анхаарлыг татахад туслах болно.

### Хүүхдүүдийн насанд тохируулан хичээлүүдийг хялбаршуул

(TNGC, 110–117-г үз).

Жишээ нь, дөрөв дэх долоо хоногийн хоёр дахь үйл ажиллагааг ахмад хүүхэд бүрт Мормоны Номны номлогчийн хэвлэлийг өгч, тэдгээрийг бусадтай хуваалцахыг урамшуулан дэмж. Бага насныханд Анхны үзэгдлийн түүхийг эргэн үзэхэд нь туслахын тулд Behold Your Little Ones –ийн 88–91-р хуудсан дээрх үйл ажиллагаа, үзүүлэн ба гарын хүүхэлдэйг ашиглаж болно.

## Дөрөв дэх долоо хоног: Би одоо номлогч байж чадна.

### Ойлгуулахыг хичээ (санаануудаасаа хуваалцаж):

Самбар дээр дараах өгүүлбэрийг бич: “Би одоо . . . хийж, номлогч байж чадна \_\_\_\_\_.” Одоо номлогч байж болохын тулд юу хийж болох талаар бодохыг тэднээс хүс. Өөрсдийн санаануудыг хажууд суугаа хүүхэдтэй хуваалцахыг тэднээс хүс. Хэдэн хүүхдээс самбарт өөрсдийн санаануудыг бичихийг урь.

### Ойлгуулахыг хичээ (гэрчлэлүүдийг сонсож):

Нэг ахмад хүүхдээс Анхны үзэгдлийн түүхээс бусад хүүхдүүд Мормоны Номын тухай сэтгэгдлээсээ хуваалцахыг тэднээс хүс. (Хүүхдүүдэд урьдчилан хэл. Тэгснээр тэд бэлтгэх хангалттай

цагтай байх болно.) Анхны үзэгдлийн түүх эсвэл Мормоны Номын талаарх өөрсдийн сэтгэгдлээ гэр бүлтэйгээ хуваалцахыг урамшуулан дэмж.

**Хэрэгжилтийг урамшуулан дэмж (дуу дуулж):** Хүүхдүүдээс бид одоо хэрхэн номлогч байж мөн сайн мэдээний дагуу амьдарч болох талаар үйлдэл үзүүлэхийг хүс. Нэг хүүхдийг сонгож ангийн өмнө гарган, Хүүхдийн Хэсгийн бусад хүүхдүүдэд өөрийн үйлдлийг үзүүлэхийг хүс. Түүнийг үйлдэл үзүүлж байхад хүүхдүүдийг “Намайг дагаад хий” (CS, 276) дууг дуулахыг хүс. Цаг байгаа бол цааш нь хэд хэдэн удаа үргэлжлүүл.



# Залбирал бол Бурхан бид хоёрын хоорондох бишрэлтэй харилцаа юм

“Харин та нарын хэн нэгэн нь мэргэн ухаанаар дутвал, бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч Бурханаас гуйг. Тэгээд түүнд өгөгдөх болно” (Иаков 1:5).

Энд дурдах санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд сургаалыг ялган таньж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн Ариун Сүнснийг мэдрэхэд нь би хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.



## Эхний долоо хоног: Би Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирч чадна.

**Сургаалыг ялгаж тань** (хичээлтэй холбоотой зүйлс үзэж): Хүүхдүүдийн өмнө хэн нэгэн эцэг, эх, хүүхэдтэйгээ гарч зогсохыг урь. Эцэг эхээсээ ямар нэгэн асуултыг асуухыг түүнээс хүс. Эцэг эхээр нь асуултанд нь хариулуул. Дараа нь эцэг эх өрөөг орхин гараад, хаалга хаахыг тэднээс хүс. Эцэг эх нь тэдэнтэй байхгүй байхад тэд хэрхэн тэдэнтэй харьцаж болохыг хүүхдүүдээс асуу (жишээ нь, захидал бичиж эсвэл утсаар ярьж). Бурхан бол бидний Эцэг, бид Түүний хүүхдүүд билээ. Бид Түүний оршихуйд хамт байхгүй байгаа учраас Түүнтэй ярих арга замыг Тэр бидэнд өгсөн гэдгийг тайлбарла. Бурхантай хэрхэн ярихыг мэдэх эсэхийг нь хүүхдүүдээс асуу. Таныг даган “Би Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирч чадна” гэж хэлэхийг хүс.

**Ойлгуулахыг хичээ** (будаж): “Би итгэлтэйгээр залбирч байна” (CS, 14) (“Behold Your Little Ones” гарын авлагын 16-р хуудсан дээрх үйл ажиллагааг хий). Хүүхэд бүрд зориулан Behold Your Little Ones, нярайн ангийн гарын авлагын 19-р хуудсан дээрх эргэдэг номыг хий. Хүүхдүүдээр зургийг нь будуул. (Ахмад хүүхдүүдээс талархалтай байдаг зүйлс болон Тэнгэрлэг Эцэгээс гуйхыг хүсч байгаа зүйлүүдээсээ бичихийг хүс. Дараа нь тэднийг Хүүхдийн Хэсэгтэй хуваалцахыг урьж болно.) Эргэдэг номоо үзэж байхдаа дууг дахин дуулуул.

**Бэлтгэл:** Хуваалцах цагаа бэлтгэхдээ хамгийн түрүүнд сарынхаа хичээлүүдийг унш. Дараа нь Хүүхдийн Хэсгийн цаг болон хэрэгцээнд зохицуулан үйл ажиллагаануудыг тэнцвэртэйгээр төлөвлө. Жишээ нь, урт үйл ажиллагааг хоёр долоо хоногт багтаан хийж болно эсвэл хүүхдүүд эргэн давтаж болох богино үйл ажиллагаанууд байж болно. (TNGC, 98–99-г үз.)

Олон янзын арга замуудаар хүүхдүүдийн ойлголт ба хэрэгжилтийг нэмэгдүүлэх үйл ажиллагаануудыг төлөвлө. Жишээ нь, энэ үйл ажиллагаануудад хүүхдүүд харж, дуулж, будаж, бичиж, сонсож мөн хуваалцдаг.



Эргэдэг ном харахад энд дар.



## Хоёр дахь долоо хоног: Судрууд надад хэзээ, хэрхэн залбирахыг заадаг.

**Сургаалыг ялгаж тань** (судрыг цээжилж): Хүүхдүүдийг Алма 13:28 дээрх дараах өгүүлбэрийг цээжлэхэд нь тусал: “Та нар Их Эзэний өмнө өөрсдийгөө даруусган, түүний ариун нэрийг дуудаж, үргэлж сэрэмжилж мөн залбираасай.” Судар хэзээ, хэрхэн залбирах ёстой талаар юу зааж байгааг ярилц.

**Ойлгуулахыг хичээ** (судруудыг уншиж, судрын түүх сонсож): Хүүхдүүдэд ямар ч үед, хаана ч байсан өөрсдийн зүрх сэтгэлдээ Тэнгэрлэг Эцэгтээ хандан чимээгүйхэн залбирч болно гэдгийг мөн бид Түүний адислалуудад талархаж, Түүнээс тусламжийг гуйх ёстой гэдгийг ойлгоход нь тусал. Дараах судрын эшлэлүүдийг самбар дээр бич: 3 Нифай 18:19; 3 Нифай 19:6–8; 3 Нифай 18:15. Мөн хэрхэн, хэзээ гэсэн үгсийг самбарт бич. Судар бүрийг олж, бид

хэзээ эсвэл хэрхэн залбирах тухай судар юу зааж буйг ярилц. Алма, Амюлек нар Зорамчуудад хэрхэн залбирахыг зааж байгаа тухай хэл (Алма 31; 34:17–27; мөн Хүүхдийн Хэсэг 4, 21-р хичээлийг үз). Түүхийг ярьж байхад тань үйлдлийг дүрслэн үзүүлэхийг хэсэг хүүхдээс хүсч болно.

**Хэрэгжилтийг урамшуулан дэмж** (мэдэрэмжээ хуваалцаж, дуу дуулж): Хэдэн хүүхдийг урьж, залбирах үедээ юу мэдэрдэг тухай хуваалцахыг хүс. Залбирлын тухай заадаг Хүүхдийн Хэсгийн дууг санал болгож болно. Зарим дуунаас дуул. Дуу бүрийн нэг буюу хоёр энгийн үгсийг хөдөлгөөнөөр орлуулахыг хүс. Жишээ нь, “залбирах” эсвэл “залбирал” гэж дуунд хэлэгдэхэд тэд гараа урдаа атган сууж болно.

## Гурав ба дөрөв дэх долоо хоног: Тэнгэрлэг Эцэг миний залбирлуудыг сонсдог мөн хариулдаг.

**Сургаалыг ялгаж тань** (судруудаас уншиж): Хүүхдүүдийг 3 Нифай 14:7, Иаков 1:5 –г олж харахыг урь. Залбирлын талаар судруудад юу гэж заасныг олохыг хүс. Хамтдаа судруудыг чангаар уншиж, юу сурсныг нь яриул. Тантай хамт “Тэнгэрлэг Эцэг миний залбирлуудыг сонсдог мөн хариулдаг” гэж хэлэхийг тэднээс хүс.

**Ойлголт ба хэрэгжилтийг чухалчил** (түүхүүдийг сонсож): Хүүхдүүдийг групп болгон хуваа. Ээлжлэн дараах буудлуудад зочил (TNGC, 179-г үз). Буудал бүрт багш нар Тэнгэрлэг Эцэг бидний залбирлуудад хариулдаг нэг арга замыг тайлбарлан заа. Залбиралд нь хэрхэн хариулсан тухай хүүхдүүдээр чөлөөтэй хуваалцуул. Нэг долоо хоногт хоёр буудал, дараагийн долоо хоногт дахиад хоёр буудал байхаар төлөвлө.

- 1-р буудал: Заримдаа залбирлууд нь бодол санаагаар эсвэл оюун ухаан, зүрх сэтгэлд ирэх шинэ санаануудаар хариулагддаг (С ба Г 8:2). Амьдралд тань тохиолдсон туршлагаасаа хуваалц эсвэл Иносын түүхийг ярь (Инос 1:4–5, 10; мөн *Behold Your Little Ones*, 17-г үз).

- 2-р буудал: Тэнгэрлэг Эцэг бусдаар дамжуулан залбирлуудад хариулдаг. Хэн нэгэн та нарын залбиралд хариулсан тухай туршлагаасаа хуваалц эсвэл Ерөнхийлөгч Томас С.Монсоны Бен ба Емили Фуллмерын залбиралд хариулсан нь хэмээх түүхийг ярь (2003 оны 10-р сарын ерөнхий чуулган, 63; эсвэл *Ensign*, 2003 оны 11-р сар, 58–59-г үз).
- 3-р буудал: Судруудаас олж болох Христийн үгсээс залбирлын хариу ирдэг (2 Нифай 32:3-г үз). Залбирал тань судруудыг уншиж байхад хариулагдсан туршлагаасаа хуваалц.
- 4-р буудал: Хожмын үеийн бошиглогчдын сургаалаас залбирлын хариу ирдэг (С ба Г 1:38-г үз). *Ensign* эсвэл *Найз*, дээрх өгүүллийг тэдэнд үзүүл. Сүмийн сэтгүүлүүдээс тэд бошиглогчдын сургаалуудыг олж болно гэдгийг хэл. Ерөнхий чуулган сонсож байхад эсвэл хожмын үеийн бошиглогчдын үгсийг уншиж байхад залбирал тань хариулагдсан тухай туршлагаасаа хуваалц.

Хүүхдүүдийн суралцах чадвар болон хэрэгцээг харгалзан **Хялбаршуулсан хичээлүүд** явуулж болно (TNGC, 110–117-г үз). Жишээ нь, *хоёр дахь долоо хоногт, бага насны хүүхдүүд судрын үгс бөглөхийн оронд “үргэлж сэрэмжилж мөн залбир” гэсэн хэллэгийг цээжилж болно.*



*Буудлууд нь олон янзын зүйлсэд суралцаж болох цөөхөн хүүхдийг хамруулсан газар юм (TNGC, 179-г үз). Том Хүүхдийн Хэсэгтэй газарт бол багш нар хүүхдүүдийн группын хооронд явж зааж болно. Энэ тохиолдолд групп нь буудал болж байна.*

# Хүндэтгэл нь Бурханаа гэсэн хайр ба хүндлэл мөн

“Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла” (Матай 22:37).

Энд дурдах санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд сургаалыг ялган таньж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн Ариун Сүнснийг мэдрэхэд нь би хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.

## Эхний долоо хоног: Хүндэтгэл нь Бурханаа гэсэн хайр ба хүндлэл мөн.

**Сургаалыг ялгаж тань** (зураг үзэж, тоглоом тоглож): Хүүхдийн залбирч байгаа зургийг үзүүлж, хүүхэд Бурхандаа хайр ба хүндэтгэлээ үзүүлж байна гэдгийг тайбарла. Хүүхдүүдэд Бурханаа гэсэн хайр ба хүндлэл гэсэн утгыг илэрхийлсэн есөн үсэгтэй үгийг бодож байгаагаа хэл. Самбарт есөн нүхтэй хүснэгт зур. Хүүхдүүдээр хүснэгтийн нүх бүрийн хүндэтгэл гэсэн үгийн үсэг бүрийг таалга. Тэд зөв үсгийг таах бүрт зохих газарт нь үсгийг бич. Ахмад хүүхдээр бичүүлж болно. Бага насны хүүхдүүдэд зураг үзүүлж, хүүхэд хүндэтгэлтэй байгааг тэд хэрхэн мэдсэнийг асуу. Хамтдаа “Хүндэтгэл нь Бурханаа гэсэн хайр ба хүндлэл мөн” гэж хэл.

**Ойлгуулахыг хичээ** (судар уншиж, дуу дуулж): Хүүхдүүдийг судраа нээж, Иохан 14:15 –г уншихыг хүс. (Хэрэв өнгөрсөн жил хүүхдүүд

энэ шүлгийг цээжилсэн бол түүнийг цээжээр уншихыг хүс.) Есүс Христэд бид хайраа хэрхэн харуулдагийг асуу. “Хүндэтгэл бол хайр” (ХДН, 12) дууг дуул. “Хүндэтгэл” эсвэл “бишрэл хүндэтгэлтэй” гэсэн үгс сонсох бүрдээ зүрхэн дээрээ гараа тавихыг тэднээс хүс.

**Хэрэгжилтийг урамшуулан дэмж** (хүндэтгэлийн тухай ярьж): Хүүхдүүдийг жижиг групп болгон хуваа. Сүм дээр байхдаа, залбирал хэлэхдээ, гэртээ эсвэл найз нартайгаа байхдаа Тэнгэрлэг Эцэг, Есүс Христэд өөрсдийн хайр ба хүндэтгэлийг үзүүлж болох арга замуудын талаар ярилц. Бага насны хүүхдүүдээр тэдний хийж чадах зүйлсийг нь зуруул. Зарим хүүхдүүдийг бүх группт хандан өөрийн санаанаас хуваалцахыг хүс. Гэртээ гэр бүлийнхэнтэйгээ мөн хуваалцахыг урамшуулан дэмж.

## Хоёр дахь долоо хоног: Ариун ёслолын үеэр хүндэтгэлтэй байх нь Есүс Христийг санахад минь тусалдаг.



**Ойлголт ба хэрэгжилтийг чухалчил** (ариун ёслолын тухай суралцаж): Бишоп эсвэл салбарын ерөнхийлөгч болон Аароны санваартан хүнийг урьж, ариун ёслолын тухай

хүүхдүүдэд заалга. Боломжтой бол хүүхдүүдийг ариун ёслолын танхимд оруулан ариун ёслолын ширээ, тэдний өвдөглөн суугаад залбирдаг газар ба ариун ёслолыг хучдаг бүтээлэг юу төлөөлдөг зэргийг заа. Бас нэгэн Аароны санваартан хүнийг урьж, долоо хоног бүр цугларагсад ариун ёслолыг түгээхийн тулд тэр юу хийдэг болохыг болон яагаад энэ нь ариун онцгой эрх болохыг тайлбарлуул. Ариун ёслолыг адислахдаа санваартнууд Бурханд ямар хүндэтгэл үзүүлдгийг хүүхдүүдээс асуу (залбирахаар сөгддөг, ариун ёслолыг цагаан бүтээлгээр бүтээдэг, зохистой хувцаслаж хүндэтгэлтэй үйлддэг). Хүүхдүүдээс ариун ёслолын үйлчлэлийн үеэр Есүс Христэд хүндэтгэл үзүүлэхийн тулд юу хийж болохыг үзүүлэхийг хүс.



**Хичээл давтах:** Сургаалыг биеийн эсвэл үзүүлэнтэй холбох нь хүүхдүүд илүү сайн тогтоон санаж үлдэхэд нь тусалдаг (TNGC, 182–183-г үз). Эхний долоо хоногийн хоёр дахь үйл ажиллагаанд гараа зүрхэн дээрээ тавихыг урьснаар хүүхдүүдэд хүндэтгэл бол Бурханы хайртай нягт холбоотойг санахад тусална. Хүндэтгэлийг урамшуулан дэмжих үедээ гараа зүрхэн дээрээ тавьж, энэ сургаалыг хэдэн сар давтан хийхийг анхаарна уу.

Хүүхдийн Хэсэгт зочин урихдаа тэднийг хүүхдүүд ойлгохоор энгийн үгээр ярихыг санууларай. Хүүхдийн Хэсэгт үг хэлэх зочдыг бишопын зөвлөл батлах ёстой.



## Гурав дахь долоо хоног: Ариун газруудад болон юмсад хүндэтгэлтэй байснаар би хүндлэлийг үзүүлж чадна.

**Сургаалыг ялгаж тань** (*хичээлтэй холбоотой үзүүлэнд оролцож*): Самбар дээр “Ариун газруудад болон юмсад хүндэтгэлтэй байснаар би хүндлэлийг үзүүлж чадна” гэж бич. Нийт Хүүхдийн Хэсгийнхэндээ уншиж өгөхийг нэг хүүхдээс хүс. Хүүхдүүдийн нүдийг аниулаад өөрөө задгай мөнгө эсвэл товч шалан дээр унаган хэрэв тэд унах чимээг сонсвол гараа өргөхийг тэднээс хүс. Сүмийн байр нь ариун газар бөгөөд томоотой сууж, анхааралтай сонсох нь хүндэтгэл үзүүлэх нэг арга зам гэдгийг хэл. Сүмийн байранд хүндэтгэлээ үзүүлэх бусад зүйлсийн талаар хуваалцахыг тэднээс хүс.



**Ойлгуулахыг хичээ** (*судрын түүхээс сонсож*): Мосе болон шатаж буй бутны зургийг үзүүлж, түүхийг Египетээс гарсан нь 3:1–10 дээрээс олж болохыг хэл. 5-р шүлгийг чангаар



*Сурахын тулд хүүхдүүд юу хийх вэ? Үйл ажиллагаандаа бэлтгэж байхдаа энэ асуултыг асуух нь хүүхдүүд сайн оролцоноор сайн сурахад нь тусална. Жишээ нь, гурав дахь долоо хоногийн гурав дахь үйл ажиллагаанд бүх хүүхдүүд ярианд оролцож, зураг үзэж, санаагаа хуваалцах боломжтой.*

## Дөрөв дэх долоо хоног: Бурхандаа хүндэтгэлтэй байх нь бусдыг хүндэлж, тэднийг хайрлахад минь тусалдаг.

**Ойлгуулахыг хичээ** (*дуу дуулж*): Дараах дуунуудыг дуул. Дууг дуулах бүртээ, дуун дээр гарсан зүйлтэй холбоотой асуудлуудын талаар ярилц.

- “Хүндэтгэл бол хайр” (ХДН, 12). “Миний хүндэтгэл үгэнд минь, үйлсэд минь харагддаг” гэсэн мөрийг давтан хэл. Тэнгэрлэг Эцэг эсвэл бусдад хүндлэл үзүүлэх ямар үгс буюу хэллэг байна вэ? Бид бусдад хүн-

уншиж, яагаад Их Эзэн Мосег гутлаа тайлахыг хүссэнийг олж сонсохыг хүүхдүүдээс хүс. Хүндэтгэлтэй байхын тулд бид гутлаа тайлах шаардлагагүй ч ариун газар ба юмст хүндэтгэлээ үзүүлэх олон арга замууд байдгийг тайлбарла.

**Хэрэгжилтийг урамшуулан дэмж** (*тоглоом тоглож*): Дараах зурагнуудаас үзүүл: ариун сүм эсвэл сүмийн байр, гэр орон, гэр бүл, хэн нэгэн залбирч байгаа, хүүхэд, судрууд, хэсэг хүүхэд, Хүүхдийн Хэсгийн анги, ариун ёслол. Зурагнуудын урдур том даавуугаар хааж, нэг зургийг ав. Урдур татсан даавууг авч, ямар зураг байхгүй болсоныг асуу. Авсан зургаа үзүүлж, зурган дээрх газар эсвэл юманд хэрхэн хүндэтгэлээ үзүүлж болохыг үзүүлэхийг хүүхдүүдээс хүс. Энэ мэтээр бусад зурагнуудтай давтан хий.



Зурагнуудыг [sharingtime.lds.org](http://sharingtime.lds.org) дээрээс авч болно.



Бусдад хэрхэн хайраа үзүүлэхийг **үлгэр жишээгээрээ заа** (ТNGC, 18–19-г үз). Хүүхдийн Хэсэгт урамшуулалт, тус дэмийг үзүүлж багш нарт тусла. Дараа нь тэд бие биенээ хэрхэн хайрлаж, урамшуулан дэмжиж болохыг ойлгож мэдэхэд нь тусал.

дэтгэлээ үзүүлж болох ямар зүйлс байна вэ? гэж асуу.

- “Би элэгсэг нэгэн баймаар байна” (ХДН, 83). Найз нартаа бид ямар арга замаар эелдэг байж чадах вэ? гэж асуу.
- “Би Тантай алхна” (ХДН, 78). Хэнд бидний эелдэг зан хэрэгтэй вэ? Тэдэнд бид хэрхэн эелдэг байж чадах вэ? гэж асуу.

# Судрууд надад Аврагчийн төрөлт ба Хоёр дахь ирэлтийн талаар заадаг

“Хүний Хүү тэнгэр элч нарын хамт Эцэгийнхээ алдрын дотор ирж, хүн бүрд үйлсийнх нь дагуу хариуг өгнө” (Матай 16:27).

Энд дурдах санаануудыг өөрийнхөө санаануудаар баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд сургаалыг ялган таньж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн Ариун Сүнснийг мэдрэхэд нь би хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.

**Судрууд:** Судруудаас унших нь хүүхдүүдийг судрын хэллэгийг ойлгоход тусалдаг. Хэцүү үгс эсвэл санаануудыг тайлбарлаж өг. (TNGC, 50–51-г үз.)

**Санамж:** Аврагчийн төрөлт тоглолтоос бусад жүжигчилсэн тоглолтонд Аврагчийг хүүхэд төлөөлөн тоглох ёсгүй.

## Эхний долоо хоног: Бошиглогчид Есүс Христийн төрөлтийн талаар бошиглосон.

**Ойлгуулахыг хичээ** (судруудыг уншиж, дүрд тоглож): Хүүхдүүдийг таван групп болгон хуваа. Групп бүрд дараах судруудаас болон бошиглогчийг төлөөлөх энгийн хувцас эсвэл таяг өг: Исаиа 7:14; 9:6 (Исаиа); 1 Нифай 11:14–21 (Нифай); Мозая 3:5, 8 (Бенжамин хаан); Алма 7:9–10 (Алма); Хиламан 14:2–6 (Самуел). Групп бүр судрыг уншиж, бошиглогч Христийн төрөлтийн талаар юу гэж хэлснийг

ярилц. Групп бүрээс нэг хүүхэд гаргаж, таяг эсвэл хувцсаа ашиглан бошиглогчийг төлөөлж, нөгөө хүүхдээр хэн гэдэг бошиглогчийг төлөөлж байгааг хэлүүлэн, тухайн бошиглогч Есүсийн төрөлтийн талаар юу гэж хэлснийг унших буюу хэлүүл. “Тэр Хүүгээ илгээсэн”(ХДН, 20) дууг дуул.

## Хоёр дахь долоо хоног: Есүс Христ төрсөн.

**Ойлгуулахыг хичээ** (дуу дуулж, зураг зурж): “Есүс Христийн төрөлтийн дуу” (ХДН, 32) дууны эхний бадгийг хамтдаа дуул. Хүүхдүүдийг дөрвөн групп болгон хуваа. Групп бүрт дараах шүлгүүдийн (2–5) нэгийг өг. Өөрсдийн авсан шүлгийн үйл явдлыг зурахыг хүүхдүүдээс хүс. Дууг бүхэлд нь дуул. Дуунд өөрсдийнх нь зурсан үйл явдал гарахад зургаа дээш өргөн бүлэгт нэгдэхийг хүс.



## Гурав дахь долоо хоног: Есүс Христ дэлхий дээр хэзээ нэгэн цагт эргэн ирнэ.

**Сургаалыг ялгаж тань** (үгс нийлүүлж): Дараах хэллэгийг: Хүний Хүү, ирэх болно, алдрын дотор, Эцэгийнхээ гэж жижиг таавар үгс болгон бич. (Таавар үгсийг [sharingtime.lds.org](http://sharingtime.lds.org) дээрээс авч болно.) Самбар дээр таавар үгсийг замбараагүй дараалалд бич. Тэдгээрийг зөв дараалалд оруулахад туслахыг хүс. (Хэсэг үгсийн таавар бэлтгэж, тэдгээрийг групп бүрээр хамтдаа ажиллан нийлүүлэхийг хүсч болно.) Хүүхдүүд хэллэгийг зөв дараалалд оруулсны дараа Матай 16:27 –г уншиж, хариултаа шалгахыг хүс.

**Ойлгуулахыг хичээ** (зурагнууд үзэж): Самбарын өмнө дөрвөн хүүхэд урин гаргаж, Леменчүүдийн Самуел, Есүсийн төрөлт, Есүс зааж байгаа нь, Хоёр дахь ирэлт зурагнуудыг барьж

зогсохыг хүс. Зураг бүрийн тухай хүүхдүүдтэй ярилц. Хүүхдүүдийг замбараагүй дараалалд зургаа барин зогсохыг хүс. Хүүхдийн Хэсгийнхнийг зураг барьсан хүүхдүүдийг хөдөлгөн, зөв он дараалалд оруулахыг хүс.

**Хэрэгжилтийг урамшуулан дэмж** (нийлүүлэх тоглоом тоглож): Самбарын голд шугам тат. Самбарын дээд талд нь “Есүс Христ дэлхий дээр хэзээ нэгэн цагт эргэн ирнэ” гэж бич. Самбарын нэг хагаст дараах асуултуудыг бич. Самбарын нөгөө хагаст судруудын эшлэлийг замбараагүй дараалалд бич.

- Христийг дахин ирэхэд ямар гайхамшгууд болох вэ? (Иосеф Смит—Матай 1:33, 36–37)
- Аврагч хэзээ ирэх вэ? (Иосеф Смит—Матай 1:38–40)

[Үг харахад энд дар.](#)



Зураг болон бусад үзүүлэнгүүдийг ашиглах нь сурсан зүйлээ ойлгож, санах тэдний чадварыг өсгөж, сургаалын зарчим эсвэл дүрслэл тэдний оюун ухаанд уяатай хадгалагдан үлддэг.

- Яагаад бид Хоёр дахь ирэлтэд бэлтгэх ёстой вэ? (С ба Г 38:30)
- Аврагч дэлхий дээр хэр удаан амьдрах вэ? (С ба Г 29:11).

Асуултын хариултыг олохын тулд багштайгаа хамтран ажиллахыг хүүхдүүдээс хүс. Хариултыг хамтдаа хэлэлц. (Итгэлдээ үнэнч байх нь [2004], 159–161-г үз.) Хоёр дахь ирэлтэнд тэд хэрхэн бэлтгэж чадах тухай асуу.

### Өөр өөр насны группууд:

Хуваалцах цагт бага болон ахмад насны хүүхдүүд хоёул хамт оролцохоор төлөвлө (TNGC, 110–117-г үз). Жишээ нь, гурав дахь долоо хоногийн хоёр дахь үйл ажиллагаанд энгийн ойлголтыг заахын тул зураг ашиглаж байгаа тул бага насныхантай ажилласан нь илүү дээр байх болно. Энэ долоо хоногийн эхний үйл ажиллагааны хувьд бол та нар ахмад хүүхдүүдээс бага хүүхдүүдэд үгсийг нийлүүлэхэд нь туслахыг хүсч болно.




## Дөрөв дэх долоо хоног: Хоёр дахь ирэлтэд бэлтгэхийн тулд би Есүс Христийг дагах болно.



Зургийг [sharingtime.lds.org](http://sharingtime.lds.org) дээрээс авах боломжтой.

**Ойлгуулахыг хичээ (судрын түүхээр жүжжиг тоглож):** Есүс сүнслэг үнэнийг заахын тулд ихэвчлэн ижил төстэй зүйлс болон нөхцөл байдлыг ашиглан сургаалт үгсээр заадаг байсан гэдгийг хүүхдүүдэд хэл. Ариун арван охидын талаарх түүхийг товчхон ярьж өг (Матай 25:1–13; мөн “Ариун арван охидын тухай сургаалт үлгэр,” *Ensign*, 2009 оны 3-р сар, 48–49-г үз). Энэ сургаалт үлгэрт Есүс Христийн Хоёр дарь ирэлтийг хуримтай зүйрлэсэн гэдгийг тайлбарла. Хэсэг хүүхдээр сургаалт үлгэрээр жүжигчилсэн тоглолт хийлгэ. Мэргэн ухаантай охидод тоглосон хүүхдүүдээс бэлтгэлтэй байх нь ямар мэдрэмжийг төрүүлж буйг асууж, Аврагчийн дахин ирэлтэд бэлтгэхийн чухал ач холбогдлын талаар ярилц.

**Хэрэгжилтийг урамшуулан дэмж (хэлэлцэн, зураг зурж):** Самбар дээр дэнлүү зур. Өдөр бүр сайн зүйлс хийж Есүс Христийг дагах нь хэрхэн дэнлүүндээ тос хийсэнтэй адил байгаа талаар ярилц. Бусдад туслах, аравны нэгээ төлөх, залбирах зэрэг Есүс Христийг дагах зарим арга замуудыг нэрлэхийг тэднээс хүс. Эдгээрийг хувь хүн бүр өөрсдөө хийх хэрэгтэй бөгөөд тэдний төлөө бусад хүмүүс



тэдгээрийг хийж чадахгүй гэдгийг тайлбарла. Хүүхэд бүрд цаас өгч, том тосны дусал хайчлахыг хүс. Тэднээс (эсвэл багш нараас) “Хоёр дахь ирэлтэд бэлтгэхийн тулд би . . . . . хийж, Есүс Христийг дагах болно \_\_\_\_\_” гэж хайчилсан дусал дээрээ бичихийг хүс. Хоёр дахь ирэлтэд бэлтгэхийн тулд хийж чадах ямар нэгэн зүйлийг бөглөн бичих эсвэл зурахыг тэднээс хүс. Хайчилсан дусал бүхий цаасаа гэртээ аваачин сурсан зүйлсээ гэрийнхэнтэйгээ хуваалцахыг урамшуулан дэмж.

**Дэнлүү болон тосны сав харахад энд дар.**



# Хүүхдийн Хэсэгт дуу хөгжмийг хэрхэн ашиглах тухай

*Хүүхдийн Хэсэгт дуу хөгжим байхын гол зорилго нь Есүс Христийн сайн мэдээг хүүхдүүдэд заах мөн түүний дагуу амьдрахад нь тэдэнд туслах явдал юм. Хүүхдийн Хэсгийн дуунууд нь суралцах явдлыг илүү таатай болгож, хүүхдүүдэд сайн мэдээний үнэнийг суралцаж мөн санахад нь тусалж, Сүнснийг хамт байлгадаг.*

*Хүүхдүүдэд дуу заахдаа ашиглаж болох ур чадваруудыг дор өгөв. Үлгэр жишээнүүд нь энэ хөтөлбөрт санал болгосон дуунуудтай ажиллахад тань туслах болно. Нэмэгдэл санаануудыг 2010 оны хөтөлбөр дэх “Хүүхдийн Хэсэгт дуу хөгжмийг хэрхэн ашиглах тухай” хэсгээс харна уу.*

## Хүүхдүүдийн анхаарлыг татах

Дуу дуулахын өмнө хүүхдүүдийн анхаарал төвлөрсөн эсэхийг хяна. Зураг, энгийн зүйлс эсвэл хүүхдүүдийг өөрсдийг нь ашиглан үзүүлэн болгож, тэдний анхаарлыг татаж болно. Та зөвхөн хоолойныхоо өнгийг өөрчилж болно. Анхаарал төвлөрүүлэх үйл ажиллагаа богино бөгөөд шууд дуундаа хандсан байх ёстой. Жишээлбэл:

- “Би Ариун сүм харах дуртай” (ХДН, 99) дууг дуулахын өмнө ариун сүм харсан хүүхдүүдээс гараа өргөхийг хүс. Хүүхдүүдийг дуулж байхдаа ариун сүмийг хараад юу мэдэрсэн талаараа бодохыг тэднээс хүс.
- Хүүхдүүд та нарын хамгийн шилдэг үзүүлэн байж чадна. “Бид энэ дэлхийд Түүний үнэнийг авчирна” (ХДН, 92) дууг дуулж байхдаа тэд зангиа эсвэл судрууд зэрэг номлогчдыг төлөөлөх энгийн зүйлсийг ашиглахыг тэднээс хүс.



Гэртээ дуугаа **давтанаар** та хүүхдүүдийн өмнө гараад ном уруугаа биш тэдэн уруу харж зааж чадна.



*Энгийн үзүүлэнгүүд тавь. Энэ нь дууны захиас дээр хүүхдүүдийн анхаарлыг төвлөрүүлэхэд тусална. Мөн энэ нь тэдний дуулж байгаа үгс үнэн гэдгийг Сүнс тэдэнд гэрчилдэг.*

## Хүүхдүүдийг сонсоход чиглүүл

Хүүхдүүд дууны үгийг сурч, захиасыг ойлгоход нь туслах асуултын хариултуудыг олж сонсохыг тэднээс хүс. “Хэн?” “юу?” “хаана?” “хэзээ?” эсвэл “яагаад?” гэсэн асуултуудын хариултыг олж сонсохыг хүсч болно. Та нар мөн хүүхдүүдийг түлхүүр үгс, холбоо үгс эсвэл тодорхой нэг үгийг хэдэн удаа дуулж байгаагаа хуруугаа даран тоолохыг хүсч болно.

Та нар “Би зүрх сэтгэлээрээ сонсох юм бол” (энэ товхимлын 28-р хуудас) гэдгийг зааж байхдаа

самбар дээр дараах асуултуудын нэгийг бич: “Аврагчийн хоолойг би хаана сонсож чадах вэ?” “Зөв шударгаар амьдрахыг хэн бидэнд заадаг вэ?” “Хэн бидэнтэй намуухнаар ярьдаг вэ?” Дуулж байхдаа хариултыг сонсохыг хүүхдүүдээс хүс. Тэгээд хариултыг сонсвол (гараа хумхин суух, босох, эсвэл чихэндээ хүрэх зэрэг) дохио үзүүлэхийг хүс. Хариултыг хамтдаа хэд дахин давтан дуул. Самбар дээр бас нэг өөр асуулт бичиж, давтан хий.

Хамт дуулахад хүүхдүүд та нарын сайн мэдээг гэсэн хайр ба идэвхийг мэдрэх болно. Аврагчийн тухай өөрийн гэрчлэлээ хуваалцахад өөрсдийг нь гэсэн Түүний хайрыг тэд мэдэрдэг.



**Хүүхдийн Дууны номон** дээр өгөгдсөн судрын эшлэлүүдээс суралцаж, дуун дээрх сайн мэдээний захиасыг заахад бэлтгэ.

## Хүүхдүүдийг оролцуул

Дуулахдаа олон янзын арга замуудаар хүүхдүүдийг оролцуул. Жишээлбэл:

- Дууны үгс ба захиасыг санахад туслах энгийн гарын хөдөлгөөнүүдийг бодож олохыг хүүхдүүдээс хүс (7-р хуудас дээрх “Хөгжмийн удирдагчид зориулсан тусламж”-г үз).
- “Бид энэ дэлхийд Түүний үнэнийг авчирна” дууг дуулахдаа номлогчдыг дүрслэхийг хүүхдүүдээс хүс. Дуулж байхдаа дороо алхах эсвэл өрөөгөөр алхан явах мөн судруудаа барихыг тэднээс хүс.

- “Хэрвээ би зүрх сэтгэлээсээ сонсвол” дууг дуулахын өмнө хүүхэд бүрд зүрхэн хайчилбар өгч, түүнийхээ нэг талд “чагнах” нөгөө талд нь “сонсох” гэж бичихийг хүс. Дуун дээр энэ үгс хэд дахин давтагддаг гэдгийг тайлбарлан хэл. Эдгээр үгсийг дуулахдаа зүрхээ зөв талдаа зааж үзүүлэхийг хүс.



[Зүрх харахад энд дар.](#)



## Дуул, дуул, дуул

Дууг дахин дахин дуулснаар хүүхдүүд илүү сайн тогтоон сурдаг.

Олон янзын хөгжилтэй арга замуудаар дууг давтан дуул. Жишээлбэл:

- Дууны аяыг эхлээд сонсох эсвэл оршил хөгжмийг даган аялах зэргээр дууны аяыг эхлэн суралц.
- “Би Бурханы төлөвлөгөөг дагах болно” (CS, 164–165) дууг давтан дуулахдаа хэдэн ширхэг замын хөдөлгөөний тэмдэг хий. Замын хөдөлгөөний тэмдэг бүр дээр дууны өөр өөр үгнээс бич. Тэмдгийг өргөн барьж, дуунд тухайн үг гарахад дуулахгүй байхыг хүүхдүүдээс хүс. Бусад замын хөдөлгөөний тэмдэгнүүдээ ээлжлэн барьж, дууг давтан дуул.

- Цаас эсвэл картонан цаасаар шоо хий. Шооны тал бүр дээр дуулах өөр өөр аргуудыг бич (жишээ нь, аяыг даган алга таших, гарын хөдөлгөөн хийх, намуухан дуулах, хөвгүүд дуулах, охид дуулах, эсвэл аяыг аялах). Бас нэг шоон дээр хүүхдүүдийн сурч байгаа Хүүхдийн Хэсгийн дууны нэрүүдийг бич. Нэг хүүхдээр эхний шоог хаяулж, дууг хэрхэн дуулахаа сонгоод, нөгөө хүүхдээр хоёр дахь шоог хаяулж аль дууг дуулахаа сонгохыг хүс.



[Шоо хийх аргыг харахад энд дар.](#)

**Шинэ дуунууд:** Та нар хүүхдүүдэд шинэ дууг танилцуулахдаа эхлээд тэдэнд дуулж өг. Дуулахаасаа өмнө хэд дахин сонссоны дараа хүүхдүүд дууг илүү сайн сурдаг.



# Хэрвээ би зүрх сэтгэлээсээ сонсвол

Намуухнаар ♩ = 88-104

Үг, аяыг Салли ДеФорд

1. Есү -

сийг дэл-хийд бай - хад би бяц-хан хүү - хэд бай-сан бол Түүн - тэй хамт ал-хаж,  
 Бо - шиг-логч-оор дам-жуу-лан хэ - лэх Хрис-тийн ү - гийг Тэр - ээр дэл-хий дээр  
 ү - нэн ба зө - вийг заа-хад би Сүн-сийг мэ-дэр - дэг. Тэр - ээр хэ - цүү үед

түү - ний ү - гийг сонс-хыг хүсэх бай - сан, Гэвч би суд-раас сурах-даа Түү - ний ү -  
 байжнад - тай я - рих мэт би сонс-дог Бо-шиг-логч би-дэнд зөв шуд-рага тай-ван  
 на - майг тайвш-руулж, Хрис-тийг гэр-чил - дэг. Над - тай на - муу - хан дуу - гаар ярьж, а -

1. 2.  
 гийг сон - сож чад-даг.  
 амь - дар - хыг заа - даг. Би зүрх сэт - гэ-лээ - сээ сонс-вол Ав-раг-чийн дууг сон - со-но.  
 мар амга-ланг өг - дөг,

3.  
 2. Амьд раг - чийн дууг сон - со-но.  
 3. Тэр *rit.*

Copyright © 2007 by Sally DeFord. Бүх эрх хамгаалагдсан.

Энэ дууг ашгийн бус зорилгоор гэрт болон сүм дээр ашиглахаар хуулбарлан олшируулж болно.

Энэ анхааруулгыг олшируулсан хуулбар бүрд бичих ёстой.

# Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд заах нь

Аврагч “Бүх хүүхдүүд чинь Их Эзэнээр сургагдах болно; мөн хүүхдүүдийн чинь амар амгалан агуу байх болно” гэж заасан (3 Нифай 22:13).

Хүүхдийн Хэсгийн удирдагчид бүх хүүхдүүдэд түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд ч гэсэн Есүс Христийн сайн мэдээг заах чухал үүрэг хариуцлагатай байдаг. Хүүхдийн Хэсэг нь хүүхэд бүрийг халуун дотноор угтан, хайрлах, арчлах, хамруулах газар мөн. Ийм уур амьсгалд хүүхдүүд Тэнгэрлэг Эцэг ба Есүс Христийн хайрыг ойлгож, мэдрэхэд хялбар бөгөөд Ариун сүнсний нөлөөг илүүтэй мэдрдэг.



Зурагнуудыг [sharingtime.lds.org](http://sharingtime.lds.org) дээрээс авах боломжтой.

**Хүүхэд бүр Бурханд үнэ цэнэтэй. Хүүхэд бүрт хайр, хүндлэл, дэмжлэг хэрэгтэй.**

Танай Хүүхдийн Хэсгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хэрэгцээг хангах ажилд бусдын зөвлөмжийг ав.


- 1. Хүүхдийн эцэг эхтэй зөвлөлд.** Эцэг эхчүүд хүүхдээ хэнээс ч илүүтэй мэддэг. Түүний хэрэгцээ, анхаарал татах, суралцах сайн аргаар хэрхэн хангахыг тэд та нарт заах болно. Жишээ нь, зарим хүүхдүүд суралцахдаа дуу хөгжмөөр маш сайн, бусад нь түүх, зураг, судар эсвэл хөдөлгөөнөөр илүү сурдаг. Хүүхэд бүр сайн суралцах арга замуудыг оролцуулсан заах олон янзын арга зүйг ашигла.
- 2. Бусад Хүүхдийн Хэсгийн удирдагч, багш нартай зөвлөлд.** Хүүхэд бүр Есүс Христийн сайн мэдээнд суралцаж, хайрыг мэдрэх арга замуудыг олохын төлөө залбир, хамтран ажилла.
- 3. Тойргийн зөвлөлтэй зөвлөлд.** Санваартны болон бусад туслах бүлгүүдийн удирдагчид онцгой анхаарал шаардлагатай хүүхдүүдэд хэрхэн туслах талаар янз бүрийн санаа оноог мэдэж байж болох юм. Нэг тойрогт дээд пристийн бүлгийнхэн долоо хоног бүр үе мөчний өвчтэй хүүхдийн

дэргэд халамжлан суух “Хүүхдийн Хэсгийн өвөөг” санал болгосон байна. (Тэр хүн долоо хоног бүр ирж сууна.) Энэ нь хөвгүүн хичээлдээ анхаарлаа төвлөрүүлж, хайрыг мэдрэхэд тусална.

Ахлагч М.Расселл Баллард “Эрхэм онцгой хүүхдүүдтэй ажиллах хүмүүст ариун нандин, уужим сэтгэлтэй үйлчлэгч байх үүрэг хариуцуулсан нь ойлгомжтой. Бурхан өнөөгийн хүүхдүүдийг хайраар, итгэлийн гал дөлөөр, тэд хэн гэдгээ мэдэх ойлголтоор дүүрэн байлгахын тулд биднийг томилсон юм” гэж заасан (“Great Shall Be the Peace of Thy Children,” *Ensign*, 1994 оны 4-р сар, 60).



**Дүрснүүдийг харахад энд дар.**



Онцгой анхаарал тавих хүүхдүүдэд хэрхэн туслах талаарх **илүү олон мэдээллийг** [lds.org/primary](http://lds.org/primary) ороод (Primary, гэснийг дарж, дараа нь Teaching All Children, Including Those with Disabilities –г дар); Teaching, No Greater Call, 38–39; ба [disabilities.lds.org](http://disabilities.lds.org) дээрээс үз.

Хөгжлийн бэрхшээлтэй зарим хүүхдүүд үзүүлдэнд илүү сайн хариулдаг. Залбирал хийх, чимээгүй болох эсвэл дуу дуулах цаг болоход энд харуулсантай адил дүрстэй үзүүлэнгүүдийг ашигла.

**Хичээлүүдийг хялбаршуул:** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ангид хуваалцах цагаа тэдэнд зориулан өөрчлөх хэрэгтэй байх. Үүнийг хэрхэн хийх талаарх зарим жишээг [sharingtime.lds.org](http://sharingtime.lds.org) дээрээс үзэж болно.



## ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэн гаргав.

© 2010 Intellectual Reserve, Inc. Бүх эрх хуулиар хамгаалагдсан. АНУ-д хэвлэв. Англи эхийн зөвшөөрөл: 3/09 Орчуулгын зөвшөөрөл: 3/09. 2011 *Outline for Sharing Time: I Know the Scriptures Are True* -ийн орчуулга. Mongolian. 08635 363

Хуудас 9: Христ Гетсаманд, Харри Андерсон, © IRI; Цовдлолт, Харри Андерсон, © IRI; Миний гар, Миний хөлийг харатгун, Харри Андерсон, © IRI. Хуудас 10: Иосеф Смит мэргэн ухааныг Библиэс эрэлхийлсэн нь, Дэйл Килборн, © 1975 IRI; Анхны үзэгдэл, Гари Л.Капп, © 2009 Гари Л.Капп; Тэнгэр элч Моронай Иосеф Смитэд үзэгдсэн нь, Том Ловелл, © 2003 IRI; Иосеф Смит Мормоны Номыг орчуулсан нь, Дел Парсон, © 1996 IRI; Аароны санваарын сэргээлт, Дел Парсон, © 1984 IRI. 11-р хуудас: Христ Төлөөлөгчдийг томилсон нь, Гарри Андерсон, © IRI. 16-р хуудас: Калифорнийн Сан Диего Ариун сүм, © 1997 Стив Трееагл. 17-р хуудас: Христ хүүхдүүдтэй байгаа нь, Гарри Андерсон, © IRI. 25-р хуудас: Тэдний тав нь мэргэн ухаантай байлаа, Волтер Рэйн, Сүмийн түүхийн музейн зураг. 27-р хуудас: Хүүхдийн дууны ном хавтсыг Филлис Ланч, © 1988 IRI. Арын хавтас: Иосеф Смит мэргэн ухааныг Библиэс эрэлхийлсэн нь, Дэйл Килборн, © 1975 IRI.

MONGOLIAN

